



М

ОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2019 • I • № 27

*Банкны
гоцжил 95 жил*

**Н.БАЯРТСАЙХАН:
2019 ОН ЭРҮҮЛ
ЧИЙРЭГ БАНКНЫ
ЖИЛ БОЛНО.**

**ГЛОБАЛ ОРЧИН:
ЭДИЙН ЗАСГИЙН
БОДЛОГО
БОЛОВСРУУЛЖ,
ХЭРЭГЖҮҮЛЭХЭД
АНХААРАХ
АСУУДЛУУД**



ЯАРМАГ ДАХЬ БАЯР НААДМЫН ТАЛБАЙД ЗАССАН
ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН БАНКНЫ ҮЗЭСГЭЛЭНГИЙН ПАВИЛЬОН.

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



Нэр: Монголбанк 95 жил
Он: 2019
Металл: Мөнгөн зоос
Жин: 155.5 грамм
Голч: 100 мм
Үнэ: 2,000,000₮
Сорьц: 999
Цуврал: Монголбанкны ойн баяр



Нэр: Монголбанк 95 жил
Он: 2019
Металл: Мөнгөн зоос
Жин: 31.1 грамм
Голч: 38.61 мм
Үнэ: 400,000₮
Сорьц: 999
Цуврал: Монголбанкны ойн баяр



Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвөөс эрхлэн гаргав.

Онцлох үйл явдал:

ХУУДАС

Үндэсний төлбөрийн системийн 2018 оны хяналтын тайланг нээлттэй тайлагналаа

4

Банкны хөгжил-95 жил:

ХУУДАС

Худалдаа аж үйлдвэрийн банк

21

Ярилцлага:

ХУУДАС

2019 он эрүүл чийрэг банкны жил болно

6

Асуулт, хариулт

ХУУДАС

Монголбанкны хэвлэлийн бага хурлаас (2019.01.24)

24

Байр суурь:

ХУУДАС

Монголын эдийн засаг 2019 онд

12

Банкир:

ХУУДАС

“Банк санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн реформуудаа цааш үргэлжлүүлэх нь чухал”

30

Нийтлэл:

ХУУДАС

Үнэ ба эдийн засаг

14

Дэлхийн эдийн засаг:

ХУУДАС

Популизмын давалгаа ба Бразил улсын одоогийн ерөнхийлөгч Жаир Болсонаро

36

Монголбанк юу хийдэг вэ?:

ХУУДАС

С.Дэмбэрэл: Судалгаа хийчихээд, хүмүүс уншихгүй байна хэмээн гомдоллож болохгүй

17

Судалгаа:

ХУУДАС

Глобал орчин: эдийн засгийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд

38

Мөнгөн тэмдэгтийн түүх:

ХУУДАС

1970-1981 оны гүйлгээний зоосон мөнгө

20

Санхүүгийн боловсрол:

ХУУДАС

Банкны салбарын тогтвортой байдал

42

Үндэсний төлбөрийн системийн 2018 оны хяналтын тайланг нээлттэй тайлагналаа

2019.01.10



Төлбөр тооцооны системийн оператор болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид, дотоодын болон олон улсын зохицуулагч байгууллагууд, хэрэглэгчдэд Монголбанкнаас төлбөрийн системд тавих хяналтын ач холбогдол, зорилгыг ойлгуулах зорилготой энэхүү тайлан нь Төлбөрийн системийн хяналтын талаарх олон улсын зарчмууд, Монголбанкнаас тавих хяналтын хамрах хүрээ, Монголбанкнаас хяналтын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ гэсэн үндсэн 3 бүлгээс бүрджээ. Төлбөрийн системийн хяналттай холбоотой үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлж байх зорилгоор “Үндэсний төлбөрийн системийн хяналтын тайлан”-г жил бүр Монголбанкны албан ёсны мэдээллийн Mongolbank.mn цахим хуудаст мэдээлж иржээ.

Шаргачин гахай жилд зориулсан дурсгалын мөнгөн зоос гаргав

2019.01.15

Монголбанк “Арван хоёр жил” дурсгалын зоосны цуврал болгож, 17 дугаар жарны “Урвуулагч” хэмээх шаргачин гахай жилд зориулсан “Монгол бодон” мөнгөн зоосыг худалдаанд гаргалаа. Монгол Улсын хөвч тайгын зэрлэг бодон гахайг дүрсэлсэн уг зоосыг 1 унци жинтэй, 38.61 голчтой 999 сорьцын цул мөнгөөр цутгажээ. Энэхүү цуврал зоосны анхныхыг улиран одож буй “Тийн унжлагат” хэмээх шороон нохой жилд зориулан “Монгол банхар” нэртэй гаргаж байв.



Монгол Улсад банк, санхүүгийн салбар үүсэж, хөгжсөний 95 жилийн ойг угтаж “Банкны хөгжил -95 жил” аян зарлалаа

2019.01.21



2019 онд Монгол Улсад банкны салбар үүсэж хөгжсөний 95 жилийн той тохиож байгаа бөгөөд 6 дугаар сарын 2-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлнэ. Тус тэмдэглэлт ойг угтаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар “Банкны хөгжил -95 жил” аяныг зургаан сарын хугацаанд хэрэгжүүлэхээр болж, олон улсын санхүүгийн байгууллага, банкны төлөөллийг оролцуулан аяны нээлтийг хийлээ. Энэ үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан хэлсэн үгэндээ, 1924 онд Зөвлөлт Орос Улстай хувь нийлүүлсэн Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкныг Нийслэл хүрээнд байгуулснаар манай улсад нэг шатлалт банкны тогтолцоо үүсч, түүнээс хойш 70 шахам жилийн дараа буюу 1991 онд хоёр шатлалтай тогтолцоонд шилжиж, орчин үеийн банк үүссэнийг юуны өмнө дурдаад, банкны салбар хамгийн хурдтай хөгжиж буй салбаруудын нэг бөгөөд манай орны эдийн засгийн хөгжлийн чухал тулгуур, дэд бүтэц болж байгааг онцлон цаашид тулгарч буй сорилтуудыг даван туулахад бүх нийтийн оролцоо чухал тул энэхүү аяныг хэрэгжүүлэх болсныг цохон тэмдэглэсэн юм. Аян хэрэгжих хугацаанд иргэд харилцагчдад чиглэсэн үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулахаас гадна тэдний эрх ашгийг хамгаалахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд анхаарч ажиллах юм.

“Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулаа

2019.01.22



Дэлхийн банкнаас хэрэгжүүлж буй “Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд “Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээний арга зүй” сэдэвт сургалт энэ сарын 14-18-нд Монголбанкинд боллоо. Сургалтыг олон улсын зөвлөх Доктор Гастон Гохоу удирдсан бөгөөд санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн гишүүн байгууллага болох Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпорацийн холбогдох мэргэжилтнүүд хамрагдлаа. Сургалтаар санхүүгийн салбарын мониторинг, санхүүгийн тогтвортой байдал, системийн эрсдэлийн талаарх ойлголт, макро зохистой бодлогын тогтолцоо, макро эдийн засаг, санхүүгийн секторын харилцан хамаарал зэрэг сэдвээр мэдээлэл өгч, сургалтад хамрагдсан нийт мэргэжилтэнд сертификат гардуулав.

Инфляцийн тайланг олон нийтэд танилцуулав

2019.01.22

Монголбанкнаас улирал бүр инфляцийн төлөв байдлын тайланг олон нийтэд нээлттэй танилцуулдаг болж, энэ сард Монголын Банкны Холбоотой хамтран санхүүгийн салбарын судалгаа шинжилгээний чиглэлийн мэргэжилтнүүдэд, мөн эдийн засагч, судлаач, аж ахуйн нэгжүүдэд 2018 оны 4-р улирлын тайланг танилцууллаа. Инфляцийн тайлан нь Төв банкны олон нийттэй харилцах харилцааны гол хэрэгслийн нэг бөгөөд мөнгөний бодлогын шийдвэрийн үндэслэл болсон тооцооллын үр дүнг багтаасан байдаг. Үүнд эдийн засгийн гадаад болон дотоод орчны шинжилгээ, цаашдын төсөөллүүд багтдаг. Тус тайланг танилцуулах уулзалтыг Монголбанк болон Монголын банкны холбоонд зохион байгууллаа.



ОУВС-ийн ажлын хэсэг Монгол Улсад ажиллаж байна

2019.01.30



Монгол Улсад хэрэгжүүлж буй Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн багийн ахлагч Жэф Готтлиб багийн гишүүдийн хамт 2019 оны 1 дүгээр сарын 28-30-ны өдрүүдэд Монгол Улсад айлчилж, бодлого боловсруулагч байгууллагуудтай уулзаж хөтөлбөрийн зургаа дахь үнэлгээний яриа хэлэлцээг хийлээ.

Энэ удаагийн яриа, хэлэлцээр Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн дэмжлэгтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилт, эдийн засгийн төлөв, цаашид арга авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд өрнөлөө.

Эдийн засгийн сэргэлт үргэлжилж, 6 хувийг давж өсөх төлөвтэй байгаа, экспортын үнэ болон гадаад орчин эдийн засгийн засгийн идэвхжилийг дэмжин хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгааг онцоллоо. Монголбанкны зүгээс инфляцийн төлөв, эдийн засгийн сэргэлт, валютын нөөцийн хуримтлал, зээлийн өсөлт зэрэгтэй уялдуулан бодлогын хүү болон макро зохистой бодлогыг хослуулсан бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар уулзалтын үеэр хэлэлцсэн болно. Түүнчлэн банкны салбарын активын чанарын үнэлгээний явц, үр дүн цаашид авч хэрэгжүүлэх, анхаарах асуудлуудын талаар ОУВС-тай үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохирлоо.



2019 ОН ЭРҮҮЛ ЧИЙРЭГ БАНКНЫ ЖИЛ БОЛНО

Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баярсайхантай 2019 оны эдийн засгийн төлөв байдлын талаар ярилцлаа.

Юуны өмнө 2018 оны эдийн засаг, банкны салбарт бий болсон үйл явдлын талаарх таны дүгнэлтийг сонсохыг хүсч байна.

2018 он эдийн засагт тулгарч байсан олон сорилтыг амжилттай даван туулж, эдийн засаг сэргэсэн, банк санхүүгийн салбарт реформ хийсэн шинэчлэлийн жил болж өнгөрлөө. Монголбанк үндсэн зорилтынхоо хүрээнд дунд хугацааны үнийн тогтвортой байдлыг хадгалж, инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн мөнгөний бодлого хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд банкуудын зээлийн хүү буурч, 2018 оны эцэст дунджаар 17 хувь болсон нь 2017 онтой харьцуулахад 2.4 нэгж хувиар бага үзүүлэлт юм. Зээлийн хүүгийн бууралтын нөлөөгөөр 2018 онд банкуудын зээл олголт, ялангуяа бизнесийн зориулалттай, төгрөгөөр олгосон зээл өнгөрсөн онуудтай харьцуулахад нэлээд нэмэгдлээ. Энэ нь бизнес эрхлэгчдийн дотоодын хөрөнгө оруулалтын эх

үүсвэрийг нэмэгдүүлж, эдийн засаг дахь нийт эрэлт өсөж, ажлын байр, үйлдвэрлэл өсөхөд чухал түлхэц болсон. Эдийн засаг хүлээлтээс давж 6.4 хувиар өсч, эдийн засгийн идэвхжилийг даган шууд хөрөнгө оруулалтын цэвэр орох урсгал 2017 онтой харьцуулахад 36 хувь өсөөд байна. “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд ОУВС болон бусад донор байгууллагаас 2017, 2018 онд нийт 970 орчим сая ам.долларын санхүүжилт орж ирсэн, экспортын голлох түүхий эдийн үнэ болон тоо хэмжээ өссөнөөс нийт экспорт 6.5 тэрбум ам.доллар давсны зэрэгцээ улсын зээлжих зэрэглэл өссөн. Банкны салбарын тулгуур хуулиуд болох Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банкны салбарын тогтвортой байдлын тухай хууль зэргийг шинэчлэн батлуулснаар Төв банк сайн засаглалын элементүүдийг нэвтрүүлэн, бодлогын шийдвэрийг хамтын зарчмаар гаргадаг болж, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шинэ чиг үүрэгтэй болсон нь яах аргагүй санхүүгийн

салбарт болсон чухал үйл явдал байлаа. Энэ нь мөнгөний бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, банкны салбарыг илүү эрүүл байлгаж, санхүүгийн зуучлалыг хэвийн үргэлжлүүлэх, эдийн засгийг тогтворжуулах, санхүүгийн секторт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх боломж нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой.

Улсын төсвийн орлого 2018 онд өсөж, төсвийн тэнцэл эерэг гарлаа. Энэхүү өөрчлөлт мөнгөний бодлогод хэрхэн нөлөөлсөн бэ?

Төсвийн орлого бүрдүүлэлт нэмэгдэж, төлөвлөгөөнөөс давсан нь нийт төсвийн тэнцлийг ашигтай байхад нөлөөллөө. Тухайлбал, 2018 оны гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн орлого 10 их наяд төгрөг давж, тэнцэл ашигтай гарсан нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэх дотоод эх үүсвэрийн хэрэгцээг бууруулсан. Төсөв хэр тогтвортой, тэнцвэртэй байна төдий чинээ мөнгөний бодлого, түүний хэрэгжилтэд том орон зай бий болгож байна гэсэн

үг. Иймдээ ч, төв банк бодлогын хүүгээ 2018 оны эхэнд бууруулж эдийн засгийн идэвхжилийг дэмжиж өгсөн. Үүний илрэл нь зээлийн хүү буурч, мөн бизнесийн зээл нэмэгдсэн явдал юм. 2018 онд төсөв, мөнгөний бодлого уялдаатай байсан нь эдийн засгийн өсөлтөд том түлхэц нөлөө боллоо.

Монголбанк 2018 онд 22 тонн үнэт металл худалдан авсан байна. Цаашид үнэт металл худалдан авалтын хувьд ямар байр суурьтай ажиллах төлөвлөгөөтэй байна вэ?

Та сая хэллээ. Энэ дүн 2017 оноос 9.5 хувиар нэмэгдэж, Монгол Улсын гадаад валютын албан нөөц (ГВАН)-ийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэж байна. Зөвхөн алтны худалдан авалтаар Монголбанк ГВАН-ийг ойролцоогоор 710 гаруй сая ам.доллараар нэмэгдүүлээ. 2018 онд “Эх орныхоо алтыг Эрдэнэсийн сандаа” аяныг улс орон даяар амжилттай өрнүүлсэн. Дархан-Уул, Баянхонгор аймагт байгуулсан алтны сорьц тогтоох, худалдан авах нэг цэгийн төв байгуулсан нь үр дүнгээ өглөө. Монголбанк 2019 онд алт худалдан авалтын хэмжээг өнгөрсөн оны түвшнээс бууруулахгүй байх чиглэлээр ажиллана. Гэхдээ алтны татварын хөнгөлөлтийн хугацааг сунгахгүй бол алт тушаалт ийм хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл үүсч болзошгүй. Өмнөх түүхээс харахад ийм эрсдэл үүсч байсан. Монголбанкны зүгээс алтны татварын хөнгөлөлтийг сунгах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа.

Та Монголбанкны үнэт металл худалдан авалт Монгол Улсын ГВАН-ийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг гэж хэллээ. ГВАН хэд

байгаа, ханшийн талаар ямар бодлого хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгөөч?

ГВАН 2018 оны эцсээр 3.5 тэрбум ам.долларт хүрсэн. Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 27.9 тэрбум ам.доллар байгаа нь бидэнд гадаад өр төлбөрийн эрсдэл өндөр хэвээр байгааг илтгэж байна. Иймд бид ГВАН-ийг цаашид тууштай нэмэгдүүлэхэд бодлогоо хандуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Монголбанк богино хугацаанд ханшийг тогтвортой байлгаж, огцом савлагаа гаргахгүй байх үүднээс валютын захад нийлүүлэлт хийдэг. Экспортын томоохон хувийг бүрдүүлдэг нүүрсний экспортод тодорхой хэмжээний саатал гарсан, мөн АНУ-ын Төв банк бодлогын хүүгээ нэмсэн зэргээс ам.долларын эрэлтийг зөвхөн Монголд биш дэлхий даяар нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Эдгээрээс үүдэлтэй төгрөгийн ханшийг сулруулах нөлөө үзүүлсэн ч, Монголбанк валютын зах дээрх оролцоо болон мөнгөний бодлогын арга хэрэгслээр эрэлт, нийлүүлэлтийн зөрүүнээс үүдэлтэй богино хугацааны огцом савлагааг зах зээлд үүсэхээс сэргийлж ажилласнаар төгрөгийн ханш тогтворжиж эхэлсэн.

Манай эдийн засаг гадаад орчноос ихээхэн хамааралтай учраас гадаад, ялангуяа хөрш орнуудын эдийн засгийн нөхцөл байдал энэ онд хэрхэн өөрчлөгдөх таамагтай байна вэ?

Манай улсын хувьд гадаад худалдааны түнш болсон хөрш орнуудын эдийн засгийн төлөв байдал болон бодлогын шийдвэр дотоод эдийн засагт тодорхой хэмжээнд нөлөөлдөг. Олон улсын байгууллагуудын үзэж буйгаар 2019

онд дэлхийн эдийн засгийн дундаж өсөлт 2.8 орчим хувьтай, манай худалдааны түнш орнууд болох Хятадын эдийн засаг 6.2, ОХУ-ынх 1.8 хувийн өсөлттэй байх төлөвтэй байна. Энэ онд АНУ, БНХАУ-ын хоорондын худалдааны зөрчил үргэлжилж, импортын бараа, үйлчилгээнд ногдуулах нэмэлт тарифууд хэрэгжих эрсдэл байгаа. Гэхдээ сүүлийн өдрүүдийн үйл явдлаас харахад БНХАУ-ын тал байр сууриа нэлээд зөөлрүүлж байна. Харин ОХУ-ын хувьд өнгөрсөн онд газрын тосны үнэ буурч, рублийн ханш суларч, татварын шинэчлэлт хийсний үр дүн эдийн засагт нь хэрхэн тусахаас хамаарна.

Таны үзэж байгаагаар гадаад худалдааны төлөв 2019 онд ямар байх вэ?

Гадаад худалдааны хувьд 2019 онд дунд хугацаандаа сайжрах төлөвтэй байгаа. Монгол Улсын экспортын бараа бүтээгдэхүүний 90 орчим хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлдэг. Үүн дотор зэс, нүүрс, алт, төмрийн хүдэр гээд голлох цөөн бүтээгдэхүүнийг дурдаж болно. Өнгөрөгч 2018 онд БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн төлөв болон АНУ, БНХАУ-ын худалдааны зөрчилдөөний тодорхой бус байдал зэргээс үүдэн зэс, алтны үнэ буурсан. ОПЕК-ийн орнууд болон ОХУ энэ оны нэгдүгээр сарын 1-ээс зургаан сарын турш үйлдвэрлэлээ танах зөвшилцөлд хүрсэн. Ираны нефтийн экспортын эсрэг тавьсан хориг арга хэмжээ, Венесуэлийн үйлдвэрлэлд үүссэн саатал зэрэг нь газрын тосны нийлүүлэлтэд тодорхой бус байдал үүсгэж байна.

2019 онд банкны салбарын дархлааг нэмэгдүүлэх, эдийн засгийн гадаад орчны нөлөөгөөр гадаад валютын урсгалаас шалтгаалсан санхүүгийн хэлбэлзлийн далайцыг бууруулах, эдийн засгийн өсөлт дагасан зээлийн огцом тэлэлтээс сэргийлэх зорилгоор бизнесийн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ.

Монголбанк 2019 онд банкны салбарт голлож ямар бодлого хэрэгжүүлэх бол?

Монгол Улс Ази тивийн улсуудаас хамгийн түрүүн активын чанарын үнэлгээ /AQR/-г 2018 онд хийлгэсэн. Активын чанарын үнэлгээний болон холбогдох бусад арга хэмжээний үр дүнг үндэслэн Монголбанкнаас төлөвлөгөө гарган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөнд активын чанарын үнэлгээний үр дүнг банкуудын тайланд тусгах, чанаргүй активыг шийдвэрлэх тогтолцоог боловсронгуй болгох, банкны салбарын тогтвортой

байдлыг хангах тухай буюу дахин хөрөнгөжүүлэх тогтолцоог нэвтрүүлэх зэрэг ажил хийж байна. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг өгсний дагуу банкууд 2018 оны турш нийт 505.4 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, 3.4 их наяд төгрөгт хүргээд байна. Эрүүл банктай байх нь эрүүл санхүүгийн салбар бий болгож, улмаар эрүүл эдийн засгийн суурь бүрдүүлдэг тул Монголбанкнаас 2019 онд банкны салбарт хийж буй ажлуудыг үргэлжлүүлнэ. Банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчинг сайжруулах талаар эрчимтэй ажиллах болно. 2019 он Монголын банкны салбарыг хүчирхэг болгох жил байх болно.

Дараагийн хийх гол ажлын нэг бол өмнө дурдсан ГВАН-ыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллана. ГВАН-ийн зохистой хэмжээ нь улс орны тусгаар тогтнолын санхүүгийн баталгаа болдог гэдгийг маш сайн ойлгох учиртай. Эдгээрээс гадна мэдээж одоо хэрэгжүүлж буй ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг амжилттай дуусгахад анхаарлаа хандуулна. Гурван жилийн хугацаатай хэрэгжиж буй тус хөтөлбөрийн үнэлгээг ОУВС улирал тутам хийж байгаа бөгөөд бид одоогийн байдлаар нийт зургаан удаагийн хөтөлбөрийн гүйцэтгэлийг амжилттай даваад байна. Цаашид хөтөлбөрөө амжилттай дуусгах нь Монголын олон улс дахь нэр хүндэд сайнаар нөлөөлөхөөс гадна, ирээдүйн он жилүүддээ илтгэлтэй байх үндэс болно.

2019 оны төсөв, мөнгөний бодлогын онцлогийн талаар энд ярилцахгүй өнгөрч болохгүй байх.

Төсөв 2019 онд нэлээн тэлж, төсвийн зардал, санхүүжилт нэмэгдэнэ. Ялангуяа, хөрөнгө оруулалт нэмэгдэж байна. Энэ нь төсвийн зардлаар дамжиж эдийн засаг тэлнэ гэсэн үг. Гадаад зах зээл 2019 онд өмнөх онуудаас илүү тодорхой бус байгаа нь түүхий эдийн үнэд нөлөөлж, улмаар манай улсын экспортод сөргөөр нөлөөлж болзошгүй. Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилтийн эх үүсвэрийг харахад гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал голчлон нөхөж байгаа хэдий ч тогтвортой биш байна. Улс төрийн орчин тогтворгүй байх нь гадаад хөрөнгө оруулалт татрах эрсдэл үүсгэдэг. Иймд улс төрийн тогтвортой орчин дахь төсөв, мөнгөний бодлогын хослол тун чухал юм.

Манай улс мөнгө угаах эрсдэлтэй орнуудын жагсаалтын “саарал” ангилалд орох эрсдэлтэй байгааг энд хөндөхгүй байж болохгүй юм. Нөхцөл байдал заасан хугацаанд сайжрах боломжтой эсэх дээр мэдээлэл өгнө үү?

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын хараат бус байгууллага болох ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага /АНДББ/-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хоёр дахь удаагийн харилцан үнэлгээг хийж, улмаар Монгол Улсыг 2019 оны зургаадугаар сар хүртэл “эрчимтэй хяналтад” авсан байгаа. ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтад оруулах эсэх асуудлыг 2019 оны 10 дугаар сарын 19-нд авч хэлэлцэх тов гарсан. Энэ жагсаалтад орохгүйн

тулд Монгол Улсын Засгийн газар 2017 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 327 дугаар тогтоолоор “Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улс юуны түрүүнд, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль эрх зүйн орчныг 2018 онд шинэчлэх ажил хийж эхэлсэн. Энэ нь Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлж, хуулийн үйлчлэх хүрээг өргөжүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрт шилжүүлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг эрсдэлд суурилан гүйцэтгэх, хуулийн нэр томъёоны тодорхойлолтуудыг олон улсын стандартад нийцүүлэх, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг эрс чангатгахад чухал алхам. Хийж гүйцэтгэж байгаа ажилд ахиц гарч байгаа ч саарал жагсаалтад орох эрсдэл хэвээр байгаа тул 2019 онд холбогдох байгууллагуудтай хамтран онцгой анхаарч ажиллана.

Монголбанкны хувьд үндсэн бодлогынхоо хүрээнд макро зохистой бодлого хэрэгжүүлж эхэлсэн нь үйл ажиллагааны хувьд анхны тохиолдол болж байна. Өөрөөр хэлбэл, энэ бодлогоор дамжуулан зээлийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэжээ гэж ойлгогдож байна.

Ер нь Төв банкны гол зорилго бол үнийн тогтвортой байдлыг хангаж ажиллах явдал байдаг шүү дээ. Өнгөрсөн оноос сэргэж буй



эдийн засгийн өсөлтийг мөнгөний бодлогын зөв арга хэрэгслээр хангаж ажиллах шаардлагатай байгаа. Эдийн засагт аж ахуйн нэгжүүдээс гадна иргэдийн хэрэглээний зээл нэмэгдсээр байна. Гэтэл зээлийн өсөлт нь эдийн засаг уналтад орсон үед иргэдийг өрийн дарамтад оруулах эрсдэл дагуулдаг аюултай. Ирээдүйд эдгээр эрсдэлээс болгоомжлох зорилгоор уламжлалт мөнгөний бодлого болох хүүгийн бодлоготой хоршуулсан макро зохистой бодлогын арга хэмжээнүүд авч ажиллаж байна. Бид 2019 онд банкны салбарын дархлааг нэмэгдүүлэх, эдийн засгийн гадаад орчны нөлөөгөөр гадаад валютын урсгалаас шалтгаалсан санхүүгийн хэлбэлзлийн далайцыг бууруулах, эдийн засгийн өсөлт дагасан зээлийн огцом тэлэлтээс сэргийлэх зорилгоор бизнесийн мөчлөг сөрсөн макро зохистой бодлогын хэрэгслүүдийг мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ. Энэхүү арга хэмжээ нь бодит эдийн засгийн идэвхжлээс хамаарч хэт

халалт үүсэх, эсвэл эдийн засгийн уналт үүссэн тохиолдолд түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Тиймээс банкны системийн эрсдэл хуримтлагдахаас сэргийлсэн макро зохистой бодлогыг хүүнд суурилсан мөнгөний бодлоготой хослуулах нь илүү үр дүнтэй байдаг.

-Макро зохистой бодлогыг эдийн засагт үүсэх эрсдэлүүдээс сэргийлэн хэрэгжүүлж байгаа гэж ойлголоо. Тэгвэл ирэх онд ямар эрсдэлүүд үүсэж болзошгүй байна вэ?

-Өнгөрсөн онд үүсээд буй эдийн засгийн өсөлт, идэвхжилийг дагаад бизнесийн зээл, иргэдийн хэрэглээний зээл нэмэгдэж байна. Манай эдийн засгийн бүтэц зөвхөн уул уурхайн салбарын гадаад эрэлтээс өндөр хамааралтай эмзэг эдийн засаг. Манай судлаачдын ажиглалтаар гадаад орчны тодорхой бус байдал цаашид улам нэмэгдэж болзошгүй. Хэрвээ экспортын орлого, улмаар эдийн

засагт орох орлого буурвал зээлийн эргэн төлөлт буурч, санхүүгийн сектор хүнд байдалд орно. Өрхийн бодит орлого буурвал иргэдийн төлбөрийн чадвар суларч дагаад зээлийн чанар муудан, нийт хэрэглээ хумигдаж, эдийн засгийн уналт үүсэх эрсдэлтэй. Түүнчлэн банкны зээл болон импортын өндөр өсөлт гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлснээр гадаад валютын нөөц болон ханшид дарамт учруулах байдал 2018 оны сүүлийн хагаст бидэнд тохиолоо. Тиймээс эдгээр эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр Мөнгөний бодлогын хорооноос гаргасан иргэдийн хэрэглээний зээлийн өр, орлогын харьцаа болон зээлийн хугацаанд дээд хязгаар тогтоох шийдвэрүүд нь 2019 оноос хэрэгжиж эхлээд байна.

Гадаад валютын орлогогүй, валютын ханшийн эрсдэлийг удирдах бололцоо хязгаарлагдмал иргэн, ААН, байгууллагад гадаад валютын зээл олгох нь харилцагчдыг гадаад секторын шокоос хамаарсан эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Иймд санхүүгийн системийн тогтвортой байдлыг хамгаалах үүднээс иргэд, ААН-д олгосон ханшийн эрсдэлтэй валютын зээлийн эрсдэлийн жинг 150 хувь болгон нэмэгдүүлж, 2019 оны нэгдүгээр сарын 1-нээс мөрдүүлэн ажиллаж байна. Ерөнхийд нь хэлбэл, банкны зээлийн хэт өсөлт, аль нэг салбар, бүтээгдэхүүн эсхүл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдахад чиглэсэн арга хэмжээг авч ажиллаж байна.

Зээлийн хүү буурч эхэлсэн үр дүн гарч байгаа хэдий ч дахин бууруулах шаардлага бийг нийгмийн хүлээлт харуулж байна. Зээлийн хүү хэзээ санаанд

хүртэл багасах бол?

Зээлийн хүүг захиргаадалтын аргаар бууруулснаар зах зээл, эдийн засагт нэмэлт гажуудал үүсгэдэг учир Монголбанкнаас баримталж ирсэн бодлого, чиглэл нь эдийн засаг, санхүү, хууль, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэх замаар зээлийн хүүг бууруулах нь зүйтэй гэж үздэг. Тиймээс “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023” баримт бичгийг боловсруулж 11 зорилт дэвшүүлэн ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын байдлаар иргэдэд олгосон зээлийн үлдэгдэлд жигнэсэн дундаж хүү 18 хувьтай байгаа нь өмнөх оноос 1.2 нэгж хувиар, ААН-д олгосон зээлийн хүү 15.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.9 нэгж хувиар буурсан үзүүлэлт. Иргэдийн зээлийн үлдэгдэл 2018 оны эцсийн байдлаар 8.9 их наяд төгрөгт хүрч 2017 оноос даруй 35 хувь өссөн. Иймээс 2019 оноос иргэдийн буюу хэрэглээний зээлийн хугацаанд дээд хязгаар тавьж, өр, орлогын харьцааг тогтоож эхэлснээр иргэдийн өрийн дарамтыг бууруулж, харин бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн зээлийн эх үүсвэр нэмэгдэх болно.

Засгийн газар оны өмнөхөн ипотекийн зээлийн шинэ журам баталсан. Ирэх оны санхүүжилт хэрхэх бол?

Засгийн газар өнгөрсөн онд 369 тоот тогтоолоороо “Орон сууцны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн журам”-ыг батлан энэ оны эхний өдрөөс хэрэгжүүлж байна. Монголбанк, Засгийн газраас ипотекийн зээлийн хөтөлбөрийн хүрээнд 2018 онд нийт 309.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 4676 иргэнд олгосон бөгөөд үүнээс Монголбанкны эх үүсвэрээс 191.2

тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2768 иргэнд, Засгийн газрын эх үүсвэрээс 118.1 тэрбум төгрөгийг 1908 иргэнд олгосон. Ипотекийн зээлийн санхүүжилтийг 2019 онд нэмж 500 орчим тэрбум төгрөг болгоно. Үүний 300 орчим тэрбумыг ЗГ-аас, Монголбанкнаас сар бүр 16 тэрбум төгрөг буюу нийт 192 тэрбум төгрөгийг санхүүжүүлнэ.

Үндсэндээ ярилцах сэдэв маань өндөрлөж байна. Сар шинийн босгон дээр бидний урилгыг хүлээн авч ярилцсанд баярлалаа.

Баярлалаа. Дашрамд хэлэх үг байна.

Тэгэлгүй яахав.

-2019 онд Монголбанк үүсэн байгуулагдсаны 95 жилийн ой тохиож байгаа юм. Анх 1924 оны зургадугаар сарын 2-ны өдөр Монгол-Оросын хувь нийлүүлсэн Худалдаа-Аж үйлдвэрийн банк байгуулагдсанаар Монгол Улсын Төв банкны түүх эхэлсэн гэж үздэг. Иймд түүхэн ойг тохиолдуулан банкны салбарыг бэхжүүлэх, эрүүл чийрэг болгоход чиглэсэн олон ажил санаачлан хэрэгжүүлэхээр ажиллаж эхлээд байна. Ингээд билгийн тооллын XVII жарны айлчлан ирж буй “Урвуулагч” хэмээх шарагчин гахай жилд Монгол түмэн минь амар тайван, эрүүл энх, аз жаргалтай, ажил үйлс нь өөдрөг, амжилт бүтээлээр арвин байхын өлзий дүүрэн ерөөлийг өргөн дэвшүүлье. Сар шинэдээ сайхан шинэлээрэй!

Уншигчдынхаа өмнөөс танд талархал илэрхийлье.

БАНКНЫ ХӨГЖИЛ-95 ЖИЛ

Монгол туургатан анхны төрт улсаа байгуулж байсан Хүннү, Түрэг, Уйгур гүрний үеэс зоосны мөнгө цутган арилжаа наймаанд хэрэглэж байсан. Чингис хаан Монголын эзэнт гүрнийг байгуулан, алт, мөнгөн зоос цутгуулж, эзлэгдсэн улс орныхоо дотоодод гүйлгээнд оруулж байсан баримт бий. Мөн Их Юань улсын үед Хубилай хааны зарлигаар 10 нэгж бүхий "Юань улсын нэвтрэх эрдэнэ" нэртэй цаасан дэвсгэртийг дэлхийн түүхэнд анх удаа гүйлгээнд нэвтрүүлж байсан билээ. Харин орчин цагийн банкны үүсэл хөгжил 1924 оноос эхлэлтэй бөгөөд энэ онд шинэ цагийн банкны хөгжлийн 95 жилийн ой тохиож байна.



Банкны салбар орчин цагт

Арилжааны 14 банкны голлох үзүүлэлтүүд (2018 оны эцсийн байдлаар)



Нийт актив = 33.5 их наяд төгрөг



Өөрийн хөрөнгө = 3.2 их наяд төгрөг



Зээл = 17.5 их наяд төгрөг



Хадгаламж = 12.1 их наяд төгрөг

МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСАГ 2019 ОНД

Олон улсын байгууллагууд 2019 онд Монголын эдийн засгийн ерөнхий төлөв байдал, өсөлт болон гарч болзошгүй эрсдэлийн талаар өөр өөрсдийн таамаглалаа хэрхэн дэвшүүлснийг хүргэж байна.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

("Азийн хөгжлийн төлөв" тайлан-2018 оны 9-р сар)

Монгол Улсын эрэлт болон экспортын өсөлтийн түвшин хүлээлтээс давсан тул эдийн засгийн өсөлт 2018 онд өмнөх тооцоолол болох 3.8%-аас давж 6.4% хүрлээ. Ийнхүү Азийн хөгжлийн банкнаас Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2019 онд 4.3% өснө гэж тооцоолж байсан төсөөллийг өөрчилж 6.1% болгон нэмэгдүүлж байна. Тус улсын эдийн засгийн өсөлт 6.3%-аас 6.4% болж нэмэгдэхэд уул уурхайн хөрөнгө оруулалтууд голлох нөлөө үзүүлсэн.

Харин бүтээгдэхүүний үнийн хувьд Монгол Улсын инфляци 2019 онд 7.0 хувь байна гэсэн төсөөллийг хэвээр хадгаллаа. 2018 оны эхний 7 сарын хувьд гадаад болон дотоод хүчин зүйлийн нөлөөгөөр Ази бүсийн инфляци нэмэгдсэн ч дундаж түвшин 3 хувьд хадгалагдлаа. Газрын тосны үнэ өссөн, гадаад валютын ханш чангарсан, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт буурсан болон улс орнуудын дотоод идэвхжилийн нөлөөгөөр цалингийн түвшин өссөн зэрэг нь инфляцийн өсөлтийг голлон тайлбарлаж байна.

Төв банкуудын уламжлалт бус мөнгөний бодлого, актив худалдан авалт (QE) хэрэгжиж эхэлснээр Ази бүсийн хөгжиж байгаа эдийн засгуудын хувьд гадаад валютын ханш суларч байсан бол актив худалдан авалтыг хязгаарлаж, эх үүсвэрийг эргүүлж татах мэдээлэл гарснаар гадаад валютын ханш чангарах хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, энэ өөрчлөлтийг ажиглах судалгааг Азийн 23 оронд хийсэн ба QE хэрэгжиж эхлэх үед тэдгээр орнын 17-д нь гадаад валютын ханш суларч, харин 6-д нь эсрэг дүр зураг ажиглагдсан байна. Харин QE-ийг зогсоох үед Энэтхэг, Индонези, Монгол зэрэг 15 улсад гадаад валютын ханш чангарчээ.



ДЭЛХИЙН БАНК

(Монгол Улсын эдийн засгийн тойм-2018 оны 7-р сар)

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2016 онд 1.2%-д хүрч байсан бол 2017 онд 5.1%, 2018 оны эхний улирлын байдлаар 6.1% болтол өсч, огцом сайжирлаа. Нүүрсний салбар болон зэсийн үйлдвэрлэл түүхий эдийн үнээс хамааралтайгаар өсч, дотоод зах зээлийн орчин сайжирсан зэрэг нь эдийн засгийн энэхүү сэргэлтэд хүчтэй нөлөөлж байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 2018 оны төгсгөлд 5.5%-д хүрэх төсөөлөлтэй байгаа бол 2019 онд 6.6%, 2020 онд 6.2% хүрэх төлөвтэй байна.

Засгийн газраас хэрэгжүүлж буй эдийн засгийг сэргээх хөтөлбөр үр дүнгээ өгч эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлсэн. Гадаад сектор сайжирч, бодлогын дорвитой арга хэмжээнүүд авснаар Засгийн газрын өрийн хэмжээг бууруулахад нөлөөлөв. Засгийн газрын өр 2017 онд ДНБ-ний 84.4%-тай дүйцэж байсан бол 2018 оны төгсгөлд 79.3%, 2019 онд 76.3%-д хүрэх төсөөлөлтэй байна.

Цаашид уул уурхайн салбарын идэвхжил нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ихээр татах боломжтой юм. Түүхий эдийн үнэ өндөр хэвээр хадгалагдаж, экспортын гүйцэтгэл сайн байгаа нь төсвийн орлогыг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Засгийн газрын зүгээс эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тал дээр анхаарч байгаа нь цаашдын эерэг өөрчлөлтүүдийг нөхцөлдүүлэх болно.

Гэхдээ цаашид үүсч болзошгүй эрсдэл болон эмзэг байдлууд оршсоор байна. Нэн тэргүүнд эдийн засаг түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдал хадгалагдсаар байна. Мөн өнгөрсөн хугацаанд эдийн засгийн өсөлт бүтээмжээс илүүтэй капитал (хөрөнгийн хуримтлал)-аар тэжээгдэж байгааг анхаарах шаардлагатай. Цаашлаад Засгийн газраас хэрэгжүүлж байгаа эдийн засгийг сэргээх хөтөлбөр бүрэн хэрэгжихгүй тохиолдолд томоохон эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.




ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН

(Дэлхийн эдийн засгийн төлөв – 2018 оны 10- сар)

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2018-2019 онд дунджаар 3.7% байхаар байгаа нь өмнөх төсөөллөөс 0.2%-аар доогуур үзүүлэлт юм. АНУ-ын хувьд эдийн засгийн өсөлтийн момент төсвийн зөөлөн бодлогоос улбаатайгаар хадгалагдах төлөвтэй байгаа ч худалдааны маргааны нөлөөгөөр 2019 оны төлөвийг бууруулаад байна. Мөн Их Британи болон Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төлөвийг 2018 оны өөрчлөлтүүдээс үүдэн бууруулсан. Харин хөгжиж байгаа эдийн засгууд, тэр дундаа эрчим хүч экспортлогчдын хувьд эдийн засгийн төлөвийг сайжруулсан. Азийн хөгжиж байгаа орнуудын эдийн засаг 2018 онд 6.1% өсөх төлөвтэй байгаа бол 2019 онд 0.2%-аар нэмэгдэх хандлагатай байна. Харин эдгээр оронд инфляци 2018 оны эцэст 5.3%, 2019 онд 5.5 хувьд хүрч өсөх хандлагатай байгаа бол урсгал дансны алдагдал 2018 онд ДНБ-ны 3.4%-аас 2019 онд 2.8 хувьд хүрч буурах төлөвтэй байна.

Монгол Улсын ДНБ-ний өсөлт 2018 онд 6.2%, 2019 онд 6.3%-д хүрч өсөх төлөвтэй байна. Харин тус улсын 2018 оны инфляцийн төсөөллийг 7.6%-аас 8.0% болгож өсгөсөн бол, 2019 оны төсөөллийг 8.0%-аас 8.1% болгож нэмэгдүүлсэн. Урсгал тэнцлийн алдагдал 2018 онд ДНБ-ний 8.3%-д хүрч өмнөх оноос 2.1%-аар буурах хандлагатай байгаа боловч 2019 онд эргэж сэргэн ДНБ-ний 10.8%-тай дүйцэхүйц хэмжээнд хүрч өсөх төсөөлөлтэй байна.

ОУВС-ийн дэмжлэгтэй хэрэгжиж буй хөтөлбөрийн тусламжтайгаар Монгол Улсын эдийн засагт эерэг өөрчлөлтүүд үргэлжилж байна. Түүхий эдийн экспортын өсөлт, хөтөлбөрийн амжилттай хэрэгжилт, Монгол Улсад итгэх итгэл сэргэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлээ. Улмаар төсөв, өрийн үзүүлэлтүүдэд ахиц гарч байна. Төсвийн зардал хяналтад байж, орлого огцом нэмэгдсэнээр, төсвийн анхдагч тэнцэл ашигтай гарлаа. Түүнчлэн төлбөрийн тэнцэл дээр сүүлийн үед дарамт нэмэгдэж байгааг эс тооцвол валютын нөөц нэмэгдсээр байна.



Б.ТҮМЭНЦЭНГЭЛ

*Эдийн засгийн шинжилгээ
бодлогын хэлтсийн захирал*

ҮНЭ БА ЭДИЙН ЗАСАГ

Үнэ бол зах зээлийн эдийн засгийн хамгийн чухал тулгууруудын нэг юм. Аливаа нэг бараа үйлчилгээний хувьд зах зээл дээрх эрэлт нийлүүлэлтийн харьцаа ямархуу байгааг илэрхийлэх сигнал нь үнэ өөрөө байдаг. Хэрэглэгчдийн хувьд үнээс хамаараад худалдан авалт хийх хийхгүйгээ шийднэ. Харин компаниудын хувьд бизнес эрхлэх, хөрөнгө оруулах, ажлын байр бий болгох, цалин хөлс нэмэх, хоорондоо өрсөлдөх сэдлийг төрүүлэхэд бараа үйлчилгээний үнэ чухал үүрэгтэй байдаг. Ийнхүү зах зээл дээр аливаа бараа үйлчилгээ борлогдох эсэх, тэрхүү бараа үйлчилгээг үйлдвэрлэхэд хэр их цаг мөнгө хүний нөөц зарцуулагдах нь үнээс хамаарч тодорхойлогдох нь түгээмэл. Энэ утгаараа үнэ нь зах зээлийн эдийн засагт нөөцийг үр ашигтай хуваарилах механизмыг бий болгодог зүйл юм.

Зах зээл дээр мэдээж маш олон төрлийн бараа үйлчилгээ арилжаалагдаж, зарим барааны үнэ өсдөг бол зарим нь хямдарч байдаг. Хэрэв том зургаар харвал эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшний өөрчлөлт буюу инфляци нь тухайн улс орны онцлог, макро эдийн засгийн байдлыг илэрхийлэх чухал индикатор болно. Олон нэр төрлийн бараа үйлчилгээний үнэ дунджаар аль чиглэлд, хэр хурдтай хөдөлж байгаа нь эдийн засагт

хэрэглээ, хөрөнгө оруулалт, санхүүгийн системийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой юм. Иймд үнийн тогтвортой байдал хангагдаж, инфляци тогтвортой бөгөөд таамагладахуиц түвшинд хадгалагдах нь макро эдийн засгийн тогтвортой байдал, хүртээмжтэй өсөлт, нийгмийн сайн сайхан байдалд эерэг нөлөөтэй.

ҮНЭД НӨЛӨӨЛӨГЧ ЗҮЙЛС

Монголын хувьд инфляци өндөр бөгөөд савлагаатай явж ирсэн. 2008-2018 оны дунджийг авч үзэхэд инфляци 10% орчим байгаа нь ижил түвшний орлоготой бусад улс орнуудаас өндөр үзүүлэлт юм. Мөн энэ хугацаанд дефляцитай сарууд ч байсан бол инфляци 30% давсан сар ч байв. Үнийн түвшний өсөлт ийнхүү өндөр хадгалагдсаар ирсэн нь хэд хэдэн суурь шалтгаантай:

- Эрс тэрс уур амьсгал: Байгаль орчны хүчин зүйл, цаг агаар аливаа орны эдийн засагт нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл байдаг. Цаг агаар нь дулаалгатай байшин барилга, 4 улирлын хувцас хунар г.м. амьжиргааны суурь зардлыг өндөр байлгах нэг хүчин зүйл болдог. Эрс тэрс уур амьсгалтай манай орны хувьд ган

эсвэл зуд болох үед мах, хүнсний ногооны үнэ хүчтэй хэлбэлздэг онцлогтой.

- Эрхэлж буй аж ахуй, аж үйлдвэрлэлийн хөгжил: Бэлчээрийн мал аж ахуй нь байгалийн эрсдэлт үзэгдлүүдэд өртөмтгийгээс гадна, үйлдвэрлэл хөгжөөгүй байдал нь импортын хэрэглээг өндөр, гадаад үнэ болон ханшийн өөрчлөлтөд дотоодын үнийг мэдрэмтгий болгодог.
- Институцийн хөгжил: Институци сул хөгжсөн байх нь макро бодлогын чанар, үр дүнд нөлөөлж, улмаар эдийн засгийн тогтвортой байдал, үнийн тогтвортой байдалд ч тусгалаа олдог.
- Дэд бүтцийн хөгжил: Далайд гарцгүй манай орны хувьд дэд бүтцийн хөгжил, тээврийн өндөр зардал нэг тулгамдсан асуудал болсоор ирсэн бөгөөд тээврийн зардал нь үнэд шингэдэг нэг чухал бүрэлдэхүүн хэсэг юм.
- Орлогын түвшин: Монгол улсын хувьд өрхийн орлогын түвшнээс хамаараад хэрэглээний сагсанд эзлэх хүнсний бүтээгдэхүүний жин өндөр байдаг. Иймд хүнсний бүтээгдэхүүний үнийн савлагаа ерөнхий инфляцийг өндөр хэлбэлзэлтэй болгодог.
- Хэрэглэгчийн зан төлөв: Тухайн үндэстний соёл, үнэлэмж, санхүүгийн мэдлэг боловсролоос шалтгаалаад хэрэглэх, хадгалах хандлага харилцан адилгүй байдаг. Монголын хувьд, орлогоо давсан зарлагатай зээлээр санхүүжүүлэх хэрэглээ харьцангуй өндөр тул эрэлтээр дамжаад үнийг өдөөх нөлөө нь хүчтэй.

ТӨВ БАНК БА ҮНИЙН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Ямар ч жижиг эдийн засаг маш олон оролцогчдын санхүүгийн шийдвэр дээр тогтдог бөгөөд инфляцид эрэлт нийлүүлэлтийн шалтгаантай олон хүчин зүйлс нөлөөлдөг. Тухайлбал, эдийн засгийн идэвхжилээс хамаарч эрэлт нэмэгдсэнээр үнэ өсөх, цаг агаарын нөхцөл байдлаас хамаарч хүнсний бүтээгдэхүүнүүдийн үнэ савлах, олон улсын хориг арга хэмжээний улмаас дэлхийн зах зээл дээрх нефтийн үнэ өөрчлөгдөх, эсхүл технологийн шинэ дэвшил гарснаар зарим бараа бүтээгдэхүүний үнэ хямдарч болно. Эсвэл даяарчлалын үр дүнд олон улсын худалдаа өргөжиж бүтээмж сайжирснаар үнэд эерэг нөлөө үзүүлэх, эсвэл хэрэглэгчдийн зан төлөв

өөрчлөгдөх, төрөөс хийх зарим зохицуулалт хийснээр үнэд нөлөөлөх боломжтой. Эдгээр хүчин зүйлсийн нөлөө нь түр зуурын эсвэл бүтцийн шинж чанартай байнгын өөрчлөлт байж болно. Эдийн засагт өрнөх эдгээр зүйлс, шокуудыг 100% хяналт дор байлгана гэдэг боломжгүй учраас инфляци зарим сард дээш доош хэлбэлзэх нь хэвийн юм.

Төв банкуудын хувьд үнийн өөрчлөлт, түүний учир шалтгаан дээр шинжилгээ хийсний үндсэн дээр ирээдүйн инфляцийг зорилтот түвшинд байлгахад чиглэсэн мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг. Энэ үед суурь инфляци буюу ерөнхий инфляцийг түр зуур савлуулах нөлөөтэй бараа үйлчилгээний нөлөөг хассан үнийн динамик хэрхэн өөрчлөгдөж буй нь нэг чухал үзүүлэлт болдог. Олон улс орны хувьд суурь инфляцийг тооцохдоо үнэ нь савлагаа ихтэй байдаг хүнсний бүтээгдэхүүн болон нефтийн үнийг ерөнхий инфляциас салгах нь түгээмэл байдаг бол зарим улс орон тухайн үед хамгийн өндөр савлагаатай байсан бүтээгдэхүүн үйлчилгээг хасч тооцох тохиолдол ч бий. Түүнчлэн, одоогийн инфляцийн статистикаас гадна, үнийн түвшний өөрчлөлтийн ирээдүйн төлөв байдал чухал үзүүлэлт болдог. Учир нь мөнгөний бодлогын үндсэн арга хэрэгслүүд нь хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдаа зэрэг эдийн засгийн эрэлт талд нөлөөлдөг бөгөөд, үр нөлөө нь тодорхой цаг хугацааны хоцрогдолтой илэрдгээрээ онцлог юм. Мөнгөний бодлогын шийдвэрийн үр нөлөө нь ийнхүү ирээдүйд илрэх тул эдийн засгийн цаашдын идэвхжил, үүнтэй холбоотой үнэ хэрхэн өөрчлөгдөхөөр байгаа вэ дүгнэхгүйгээр оновчтой шийдвэр гаргах аргагүй юм. Харин урт хугацаанд төв банкуудын хувьд хүлээлтийг оновчтой удирдах замаар инфляцийг зорилтот түвшинд хадгалах нь мөнгөний бодлогын гол зорилт болж байна.

Төв банкны тухай хуулинд Монголбанкны үндсэн зорилтыг “төгрөгийн тогтвортой байдал” хэмээн зааж өгсөн байдаг. Төгрөгийн тогтвортой байдлын хэмжүүр болгож жил бүр УИХ-аас баталдаг Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлд инфляцийн зорилтот түвшнийг тодорхойлж өгдөг. Монголбанк 2019-2020 онд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг жилийн 8% орчимд тогтворжуулах зорилттой ажиллаж буй. Төв банк өндөр бөгөөд савлагаа ихтэй явж ирсэн инфляцийг 8% орчимд тогтворжуулах, цаашид дунд хугацаанд шат дараатай буулгах стратеги хэрэгжүүлж байгаа гэж ойлгож болох юм.

Зорилго:

Монгол Улсын хөгжил, эдийн засаг болон санхүүгийн бодлогын шийдвэрт дэмжлэг болохуйц суурь судалгааны ажлуудыг өргөн хүрээнд хийж гүйцэтгэх, төрийн албан хаагчид болон санхүүгийн салбарын мэргэжилтнүүдэд зориулсан дунд болон ахисан түвшний сургалт явуулах үндсэн зорилготой.





С.ДЭМБЭРЭЛ: СУДАЛГАА ХИЙЧИХЭЭД, ХҮМҮҮС УНШИХГҮЙ БАЙНА ХЭМЭЭН ГОМДОЛЛОЖ БОЛОХГҮЙ

Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгийн захирал С.Дэмбэрэлтэй ярилцлаа.

ТАНАЙ ТӨВ БАЙГУУЛАГДААД ЖИЛ Ч БОЛООГҮЙ БАЙНА. ГЭТЭЛ ТОМООХОН СУДАЛГААНУУДЫГ ХИЙГЭЭД АМЖЖЭЭ. ЭНЭ ҮР ДҮНГЭЭСЭЭ ЭХЛЭЭД ХУВААЛЦАНА УУ?

Хүрээлэн маань өнгөрсөн оны тавдугаар сард байгуулагдсан. Бид зорилтынхоо хүрээнд төв банкны системийн хэмжээнд макро болон суурь судалгаануудыг хийгээд, эхнээсээ үр дүн нь гарч байна. Ямартай ч эхний ээлжинд Судалгаа статистикийн газрын ажилтай давхцахааргүй, аль болохоор уялдуулсан, өмнө нь хийгдэж байгаагүй судалгаануудад төвлөрч ажилласан. Тухайлбал, төлбөрийн тэнцлийн статистикаар эхэлж, өрхийн эдийн засгаар төгсгөдөг, нийгмийн даатгалын тогтолцоо эдийн засгийн ерөнхий анализыг нэлээн гүнзгийрүүлсэн. Өөрөөр хэлбэл, ДНБ-ний өсөлтийн анализыг бүрдэл хэсэг болгоноор нь заавал эконометрикийн арга хэрэглэлгүйгээр сонгодог аргуудаар тооцоолсон өсөлтийн дүн шинжилгээний альтернатив аргуудыг тооцоолох ажил хийгдэж байна. Хэрэглээ хөрөнгө оруулалтын асуудал байна. Ялангуяа, ДНБ-ний зардал болон эрэлтийн талаас нь авч үзсэн. Үүний дотроос хэрэглээг онцлон үндэсний хэмжээний түүвэр судалгаа эхлүүлсэн. Инфляцийн хувьд авч үзье. Төв банкны гол зорилго болох үндэсний мөнгөн тэмдэгтийн

тогтвортой байдлыг хангах. Энэ нь бодит амьдрал дээр ханш болон үнийн тогтвортой байдал гэдэгтэй хамт байж, Монголбанкийг валютын ханшийг хүссэн түвшинд түүний дотор улстөрчдийн хүссэн түвшинд барих тийм зорилт руу шахаад байдаг. Гэтэл ханшийн дэглэм нь зохицуулалттай хөвөх болон чөлөөтэй хөвөх дэглэмтэй улс орнуудын хувьд бол үнийн тогтвортой байдалтай шууд холбоотой. Энэ тохиолдолд үнийн тогтвортой байдал болон үндэсний мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдал гэдгийг хооронд нь ялгаж салгаж, энэ талын ойлголтыг шийдвэр гаргагчдад өгөх тал дээр бид ажиллаж байна. Ханшийн хэлбэлзлийг тал бүрээс нь судалсан тэнцвэрт ханшийн асуудал, өнгөрсөн түүхэн хөдөлгөөний хэлбэлзлүүд, хэлбэлзлүүдийн ард эдийн засгийн ямар шалтгаан байсан эдийн засгийн бус ямар шалтгаан байна, хүлээлтийн ямар шалтгаан байсан байна гэх мэтийн зүйлүүдэд илүү анализ хийсэн судалгаануудыг мөн хийлээ.

**СУДАЛГАА ХИЙДЭГ ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН
БУС ОЛОН БАЙГУУЛЛАГУУД БАЙДАГ. ЭД
ХООРОНDOO ХЭР УЯЛДАА ХОЛBOOTOЙ ЮМ
БОЛ, ТУХАЙЛБАЛ ТАНАЙ ТӨВИЙН ХУВЬД?**

Бүхэлд нь харвал манай Монголбанкны судалгаа, шинжилгээний аппаратад дутагдаж байгаа нэг зүйл нь үндэсний тооцоо ба эконометриксийн аппарат хоёрыг хооронд нь уялдуулах. Динамик статистик болон дискретив гэсэн энэ статистикийн түвшнүүдийг хооронд нь уялдуулах тийм шаардлага харагдсан. Тийм учраас Монголбанк дахь манай хүрээлэн, Үндэсний статистикийн хороо, ERI (Эдийн Засгийн Судалгааны Хүрээлэн) хамтраад үндэсний тооцооны чиглэлээр өнөөдрийн байдлаарх хөгжил, тоон үзүүлэлтүүд ямар байдлаар илэрч байна. Цаашдаа энэ чиглэлээр манай хүрээлэн, ҮСХ болон бусад байгууллага яаж хамтран ажиллах талаар хурал хийсэн нь шинэлэг зүйл болсон. Энэ оны хамгийн гол онцлох зүйл бол сонгуулийн жил ойртож байгаа явдал. Эндээс улс төрчдийн хамгийн их хүсээд байгаа нь зээлийн хүүгийн асуудал, ард иргэдийн зээлийн хүү буураасай гэсэн хүлээлт байгаа бөгөөд энэ талаар бас хоёр гурван ч удаа хурал хийсэн. Энэ хурал нь зээлийн хүүний тааз тогтоох туршлага манайд болон бусад улс оронд ямар байгааг олон улсын туршлагауудад үндэслэсэн. Гэхдээ гурван улсын талаар уншаад ингэдэг, тэгдэг юм байна гэх биш, зуу орчим улсын талаар уншаад жишээн дээр нь зөв шийдвэр гаргах үр дагавар нь ямар байж болох талаар ажил хийсэн байгаа юм. Дээр нь үүний эрх зүйн асуудлыг ярих хэрэгтэй. Бид зээлийн хүүг бууруулахдаа дандаа эрх зүйн орчинг орхигдуулж байсан. Энэ талаас нь судалгаа, хэлэлцүүлгүүд хийсэн. Банк санхүүгийн тогтвортой байдлын хувьд чанаргүй зээлийн хувь хэмжээний өөрчлөлт зээлийн нийлүүлэлтэд хэрхэн нөлөөлж байгааг болон макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн чанаргүй зээлд хэрхэн нөлөөлж байгаа зэргийг судалж “Монголбанкны судалгааны товхимол” болон манай хүрээлэнгээс эрхлэн гаргаж буй “Мөнгө, Санхүү, Баялаг” сэтгүүлүүдэд хэвлүүлсэн.

ХАМГИЙН ГОЛ НЬ СУДАЛГААНУУДЫГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД АВЧ АШИГЛАХ НЬ ЯМАР БАЙДАГ ЮМ БОЛ? ТАНАЙ ХҮРЭЭЛЭН БАЙГУУЛАГДСАНЫ ГОЛ ЗОРИЛГО НЬ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГ БОДЛОГЫН ШИЙДВЭРТ ТУСГУУЛАХАД БАЙХ. ЭНЭ ТАЛААР ЯРИАГАА ҮРГЭЛЖЛҮҮЛБЕ.

Нэг судалгаа хийчихээд вэб сайт дээр тавиад тэрийг нь нэг улс төрч Дорж олоод уншина гэдэг тийм зүйл байхгүй болсон. Ийм зүйл Монголд 1990 оноос хойш байгаагүй. Энэ байдал бидний социалист нийгэм гэж ярьдаг тэр нийгмээс ч одоо дор байгаа. Тэр үед хүчтэй

судалгааны хүрээлэнгүүд байдаг байсан. Гэхдээ одоо энэ нь муудсан гэсэн үг биш. Өнөөдөр Монгол Улсад эдийн засгийн судалгаа шинжилгээний ТИНКТАНК гэж хэлж болох ганцхан байгууллага байгаа нь Монголбанк. Учир нь Монголбанк өнөөдөр Монгол Улсын оюуны ТИНКТАНК. Энэ утгаас нь аваад үзвэл, Монголбанкны хийсэн судалгаануудыг вэб сайт дээрээ тавиад, хэвлэж, хурал зөвлөгөөн хийхэд бодлого боловсруулагчид буюу ялангуяа, УИХ-ын гишүүд сайд нар ирэхгүй. Тэр хүмүүсийг ном уншдаггүй гэхээр бас биш хурал дээрээ уншсан бололтой мэдээлэлтэй байгаад байдаг. Энэ юу гэсэн үг вэ гэхээр, бидний хийсэн судалгааны нийлүүлэлт, тэнд байгаа эрэлт хоёрын хооронд тоон болон чанарын ялгаа байгаа учраас эрэлт талаас нь ажиллах хэрэгтэй байна. Яаж ажиллах вэ гэхээр, судлаачдын хэллэг үг яриагаар шууд хүргэхэд ойлголтын зөрүү гарна. Манай “Эдийн Засгийг Энгийнээр” гэсэн сэтгүүл шиг энгийнээр суурь ойлголтууд, суурь зарчмуудыг хэлэх юм бол шийдвэр гаргалтын нөгөө талд илүү эмх замбараатай системтэй ойлголтууд бий болно. Ийм нөхцөл бүрдсэний дараа нь нийлүүлэлт хийвэл шингээх чадвар илүү нэмэгдэнэ гэсэн үг. Түүнээс биш бид судалгаа гаргасан уншихгүй байна гэсэн гомдол гаргаад байж болохгүй. Энэ асуудал нь дан ганц Монголд байдаггүй зүйл юм. Тиймээс ч академик эдийн засаг гэж байдаг. Улс орнуудын эдийн засгийн судалгаа шинжилгээн дээр суурилан хөгжсөн шалтгаан нь тухайн улс орны улс төрчдийнх нь амнаас гарч байгаа үгсийн санд нь хэр зэрэг эдийн засгийн үг хэллэг хэрэглэгдэж байна гэдгээс нь хэмжиж болно.

ТӨВ БАНКНЫ БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ЗОРИЛГО НЬ ХҮЛЭЭЛТИЙГ УДИРДАХ БАЙДАГ. МЭДЭЭЖ, СУДАЛГААНЫ АЖЛУУДЫГ АМЬДРАЛД ОЙР, ЭНГИЙНЭЭР ОЛОН НИЙТЭД ХҮРГЭСНЭЭР ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ХҮЛЭЭЛТИЙГ УДИРДАХАД ТҮЛХЭЦ, ДЭМЖЛЭГ БОЛОХ БАЙХ?

Манай хүрээлэнгийн анхны бүтээл нь нэг хуудастай инфляцийн календарь байсан. Тэрний дараа валютын ханшийн талаар календарь гаргасан. Энэ бол хүлээлт, өнгөрсөн үеийн түүх. Яг тэндээс шийдвэр гаргагч календарийг хараад монгол улсын инфляци иймэрхүү байдлаар явж ирсэн юм байна гэж мэдэж авна. Их мэдээлэл уншилгүйгээр энэ оны арван хоёр сард ийм шалтгаантайгаар инфляци бий болсон гээд дараа сарын талаар хүлээлт үүснэ. Тэр хүн суурь инфляци, ерөнхий инфляци гэдгийг сэтгүүл, календариасаа

ойлгоод авсан бол бид эрэлтийг-бодлогын эрэлтийг бий болгож байна. Энгийн зүйл хэлье. Хуралд ирэх урилга явууллаа, гоёор хийгээд явууллаа гээд ирэхгүй, ажилтай гээд их сайндаа туслахаа явуулдаг.

Монголбанкинд 2013 оноос хийсэн ЖДҮ-ийн судалгаа эсвэл инфляцийн хүлээлтийн судалгааг бид нар дотоод хэрэглээндээ бас л дутуу ашиглаж байна. Энэ дутуу ашиглаж байгаа зүйлээ УИХ-ийн 76 гишүүнд эсвэл яамдад тараасан байхад ганцхан гишүүн хурал дээр Монголбанкнаас гаргасан ийм судалгаа байна гээд хэлж байх жишээний. Тэгэхээр ажлуудаа бас явуул гэсэн үг. Хажуугаар нь нөгөө эрэлтийнхээ бодлогын судалгааг шингээж авах чиглэлээр зөвхөн хүрээлэн төдий биш Монголбанкны ОНБМТ-ийн санхүүгийн мэдлэгийг багаас нь гэдэг энэ зөв гэхдээ энэ бол нэг хэсэг нь гэтэл хамгийн гол хэсэг нь хүлээлтийг удирдах, хүлээлтэд эергээр нөлөөлөх ийм үйл ажиллагааг Төв банкны гол шалгуур гэж авч үздэг. Нэгэнт л энэ хүлээлт дээр ажилладаг байгууллага юм бол инфляцийн хүлээлт, ханшийн хүлээлт, эдийн засгийн хүлээлт энэ хүлээлтийг энд ажилладаг бүх нэгж тал талаас нь ажиллана гэсэн үг. Түүний нэг нь манай хүрээлэн.

ТАНАЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ӨНГӨРСӨН ОНД МОНГОЛЫН ТОП-200 АЖ АХУЙН НЭГЖИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨӨЛӨЛТЭЙ УУЛЗАЛТ ХИЙЖ, САНАЛ, БОДЛЫГ НЬ СОНССОН. ЭНДЭЭС ЯМАР ШИЙДЭЛ, ҮР ДҮНД ХҮРСЭН БЭ?

2018 онд Монголын топ 200 ААН-тэй уулзсан. Тэндээс МБГ, ЭЗССХ нийлээд МонТоп-200 гэсэн индекс гаргахаар болсон. Топ ААН-үүд Монгол улсын валютын нөөц, төсвийн орлогын ихэнхийг бүрдүүлж байна. Энэ гол нийлүүлэгч нартайгаа тэдний санаа бодол буюу сэтгэл санаа ямар байна, тэдний 2019 оны эдийн засгийн өсөлтийн хүлээлт ямар байна, ажил эрхлэлтийн хүлээлт, компанидаа ямар шинэ технологи, ШУ-ны дэвшлийг хэрэгжүүлэх гэж байгаа, хөрөнгө оруулалтынх нь хүлээлт гэх мэтийн талаар судлах нь цаашдаа мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой хэрэгтэй. Тийм учраас МБГ хүрээлэн хоёр энэ ажлыг хагас жил болгон тогтмол хийх төлөвлөгөөтэй байна.

ТАНАЙ ТӨВ СУДАЛГААНААС ГАДНА, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД СУРГАЛТ ЯВУУЛАХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ. ҮҮНИЙ АЧ ХОЛБОГДЛЫГ ХЭРХЭН ҮЗЭЖ БАЙНА ВЭ?

Сургалт бол танхимд хүмүүс цуглуулаад лекц

унших бол сургалтын сонгодог хэлбэр. Сургалтыг олон өөр аргаар хийх хэрэгтэй. Жишээлбэл арилжааны банкуудын хараат бус гишүүдийн дунд сургалт явуул гэсэн нэрсийг нь харахад юун сургалт явуулах хүмүүс, манай Монголын арилжааны банкуудын түүх болсон хүмүүс сууж байсан. Монголбанкны өмнөх ерөнхийлөгч хүртэл сууж байсан. Тэгэхээр би тэр хүмүүст сургалтыг ямар хэлбэрээр явуулах вэ? Тиймээс бид хийсэн тайлан судалгаагаа танилцуулна, хүрээлэнгийнхээ зорилгыг танилцуулна ингэснээр тэр хүмүүсээс санал бодлыг нь асууна. Ингэснээр бид тэр хүмүүсээс суралцаж байна. Энэ бас нэг сургалт. Учир нь бид бас суралцаж тэр хүмүүс мэдээлэл авж бас суралцаж байна. Одоо 2019 оны 2-р сард 2018 оныхоо судалгааны үр дүнгээр ССГ, МБГ, ЭЗССХ хамтарч шинэлэг байдлаар сургалт хийх гэж байна. Тийм учраас “ТИНКБАНК” гэдэг шинэ нэр өгсөн. ТИНКТАНК гэж байдаг шиг түүрүүн хэлсэнчлэн Монголбанкны судалгааны ажил болон Монголбанк бол ТИНКТАНК. Монгол улсад байгаа цорын ганц хүчирхэг ТИНКТАНК бол Монголбанк юм. Ер нь хурлууд дээр өмнө нь бол ихэвчлэн оюутнууд сууж байдаг байсан. Одоо тэрний оронд сургууль болгоноос багш нарынх нь багийг уриад урьдчилж илтгэлүүдийнхээ сэдвийг явуулаад тэгээд энэ илтгэлүүдийн дэлгэрэнгүй нь энэ сайт дээр байрлаж байгааг хэлээд сургууль болгон ирэхдээ нэгээс гурван асуулт бэлдэж ирнэ үү гээд тэгээд сургалтын өдөр харилцан ярилцлага хэлбэрээр явуулах юм. Энэ хурлаар бидний төлөвлөсөн наймаас есөн илтгэл тавигдах болно. Тэрэн дээрээ олон улсын судлаачдын бодол санааг нэмж өгөөд ирсэн хүмүүсээсээ санал зөвлөмж аваад дараа нь нэгдмэл байдлаар олон түмэнд хэвлэмэл байдлаар, онлайн байдлаар хүргэх юм. Энэ маань бас л сургалтын нэг хэлбэр. Мэдээж хэрэг сургалтын модуль гэж гаргасан Монголбанкны төв оффисын ажилчид, орон нутгийн салбарын ажилчид, олон нийт, шийдвэр гаргагчид гээд бүгдэд нь өөр өөр сургалт хэрэгтэй. Залуу ажилчид орж ирэх үед компьютер өгөөд суулгачихдаг. Тэрний оронд тэдэнд ахмад туршлагатай ажилчид ярьж өгөх хэрэгтэй. Энэ бас сургалт тийм учраас Sharing and Gaining гэсэн залуучуудын сургалт эхлэх гэж байгаа. Энэ жил МБГ, ССГ, ЭЗССХ хагас жил тутам судалгааныхаа талаар хоорондоо хуваалцаж, санал бодлоо солилцох хурал хийдэг уялдуулдаг механизмыг оруулж өгсөн байгаа.

ЯРИЛЦАНД БАЯРЛАЛАА.

1970-1981 ОНЫ ГҮЙЛГҮҮНИЙ ЗООСОН МӨНГӨ

1, 2, 5, 10, 15, 20, 50 мөнгө, 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй зоосыг 1970, 1977 онуудад БНАГУ-д, 1980, 1981 онуудад БНМАУ-ын Зоос гоёлын үйлдвэрт үйлдвэрлэж, гүйлгээнд гаргажээ.

1-5 МӨНГӨ:

Нүүр тал: Бадам цэцгэн суурин дээр “мөнгө” гэж кирилл үсгээр, нэрлэсэн үнийг араб тоогоор тус тус бичсэн.

Ар тал: БНМАУ-ын төрийн сүлдийг дүрслэн, улсын нэрийг “БНМАУ” гэж кирилл үсгээр товчлон, оныг араб тоогоор бичсэн.

10-50 МӨНГӨ

Нүүр тал: Тариан түрүүний дээд талд “мөнгө” гэж кирилл үсгээр, нэрлэсэн үнийг араб тоогоор тус тус бичсэн.

Ар тал: БНМАУ-ын төрийн сүлдийг дүрслэн, доод талд нь оныг араб тоогоор, хагас дугуйруулан улсын нэрийг кирилл үсгээр тус тус бичсэн.





ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН БАНК

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЭХЛЭЛ

1921 онд хоёр орны найрамдлын хэлэлцээр, түүний нэмэлт протоколын ёсоор Монгол Улс Зөвлөлт Орос улсаас авсан зээлд тулгуурлан үндэсний мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, үндэсний банкны дүрмийн төслийг боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэжээ.



КОМОР, ВАЛЕНТИН ИОСИФОВИЧ

1888 онд Хаант Орос (одоогийн Польш)-ын Люблинская губернид төрсөн. 1924-1925 онд Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн банкны Ерөнхий хорооны даргаар ажиллаж байсан. 1938.9.10-нд улс төрийн хилс хэргээр хэлмэгдсэн.

1 922 оны хоёрдугаар сарын 28-нд Улсын Түр Цагийн хурал “Хоршоо сайжруулах банк” нээх шийдвэр гаргажээ.

1924 оны эхээр ЗОУ-аас хоёр этгээдийн хувь нийлсэн Монголын аж үйлдвэрийн банкныг Нийслэл Хүрээнд байгуулах тул 64 зүйл бүхий тусгай дүрэм төлөвлөн Монголын Засгийн газраа ирүүлжээ. Монголын Засгийн газраас банкны дүрмийн төслийг хянан хэлэлцээд “*манай улсаас тусгай улсын сангийн банк нээн байгуулах нь эрхбиш ашиг тустай болох бөгөөд уг төлөвлөсөн дүрэм нь их төлөв нийлэмжтэй болсон мэт ба гагцхүү уг банкны гол мөнгөн хөрөнгийг анх удаа 25 түмэн алтан төгрөгөөр байгуулна хэмээсэн нь хараахан хомс бөгөөд аливаа худалдаа, аж үйлдвэр хувилах гүйлгэх зээлдүүлэх зүйлд хүрэлцэхгүй болуужин хэмээхийн дээр энэ зүйлийн банкныг Монголын аж үйлдвэрийн банк хэмээн нэрийдэж Нийслэл Хүрээний газраа байгуулах тул Монголын олон ардаас эрхбиш тусгай хувь үлэмжхэн нэмэгдүүлэн оруулбаас ямар бол хэмээх зэргээр” ...тогтоож уг дүрмийг хянан засамжлах комиссыг томилсон байна. Мөн*

оны гуравдугаар сарын 27-28-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкны дүрэм ба комиссын тогтоолыг баталж, банкны төлөөлөгчдийн нийтийн хурлыг зарлан хуралдуулах, төлөөлөгчдийг томилон илгээх ба мөнхүү банкны хөрөнгө болгох 10 түмэн алтан төгрөгийг арван дөрөвдүгээр оны төсөвлөсөн дансанд оруулан гүйцэтгэх явдлыг Сангийн яамнаа даалгаж, хувь нийлүүлсэн банк байгуулах гэрээ бичгийг хэлэлцэн тогтоох бүрэн эрхт төлөөлөгчөөр Гадаад явдлын яамны сайд А.Амарыг томилжээ.

1924 оны дөрөвдүгээр сарын 7-8-нд Монголын худалдаа аж үйлдвэрийн банкны хувь нийлүүлэгчдийн үүсгэн зохион байгуулах нэгдсэн хурал Нийслэл Хүрээнд болж, банкны зөвлөлийн гишүүнээр Э.Ринчино, Б.Дорж, Ж.Цэвээн, Н.Жадамба, А.Н.Васильев, И.И.Бем, П.Н.Шастин, орлогч гишүүнээр Б.Буянчуулган, Намсрай, Даваа, В.И.Юдин, В.Г.Дадидана нарыг баталжээ. Монголын Худалдаа аж үйлдвэрийн банкны үйл ажиллагааг 1924 оны

ЗӨВЛӨЛТ УДИРДЛАГА

Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн банкны удирдлага нь Зөвлөлтийн хүмүүсээс бүрдэж байв.





ДАЙЧИН БЭЙСИЙН ХОРОО

Улаанбаатар хотын Барилгачдын талбай орчимд Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошууныхан оршин суудаг байснаас энэ хавийг Дайчин бэйсийн хороо гэж нэрийддэг байжээ. Тус хорооны нутаг дэвсгэр буюу Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейн зүүн өнцөг хавьд орших энэхүү дан байшинд Худалдаа аж үйлдвэрийн банк анх байрлаж байв. 1924 он.

зургадугаар сарын 2-нд нээн эхлүүлжээ. Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн банк байгуулахдаа “Монголын Худалдаа, аж үйлдвэрийн банк”, “Монголбанк” гэсэн нэрийг хэрэглэдэг байсан ч албан хэрэгт ихэвчлэн “Монголбанк” гэж нэрлэж байжээ.

Энэхүү банкиг зохион байгуулагчид нь Зөвлөлтийн талаас ЗСБНХУ-ын Сангийн ардын комиссарын газар, Монголын талаас Монголын Засгийн газар байв. Банкны байгууллага нь дүрмийн ёсоор нөхөрсөг харилцаат ЗХУ, Монголын хоорондын эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, Монголд худалдаа аж үйлдвэр хөгжүүлэх, бас өөрийн ажиллагааны хүрээнд мөнгөний эргэлтийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлж Монголын Засгийн газрын улсын төсвийн орлого, зарлага кассын тооцооны ажиллагааг хариуцах, бас Засгийн газартай тусгай хэлэлцээр байгуулсны үндсэн дээр бусад даалгаврыг гүйцэтгэх үүрэгтэй байв. Банкны үндсэн хөрөнгө эхлээд 250 мянган алтан рубль байсан бөгөөд банкны хувь нийлүүлсэн тэмдэгтийн 80 хувийг уг банкиг байгуулагч нарт, үлдэх 20 хувийг үйлдвэрлэлд урьж оролцуулсан хүмүүст ногдуулахаар хуваарилжээ.

Монголын Худалдаа аж үйлдвэрийн банк анх ямар бүтэцтэй байсан нь тодорхойгүй ч 1925 онд Ерөнхий хороо, нарийн бичгийн даргын анги, санхүү эдийн засгийн товчоо, төв нягтлан бодох, гүйлгээний хэлтэс, шалган байцаах хэлтэс, кассын хэлтэс, эмиссийн хэлтэс гэсэн бүтэцтэй байжээ. Монголбанк анх

22 орон тоотой, үүнээс 18 нь Зөвлөлтийн мэргэжилтэн, монгол ажилчин 4 байжээ. Монголбанкны анхны салбарыг Алтанбулагт нээсэн бөгөөд банкны салбарын даргаар Ф.С.Власов, няраваар И.В.Маркевич нар ажиллаж байв.

БНМАУ-ын Их Хурлын шийдвэрийг үндэслэн Засгийн газраас 1925 оны хоёрдугаар сарын 22-нд мөнгөний шинэчлэл явуулах тухай тогтоол гаргаж үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах эрхийг Монголбанкинд олгожээ. Мөн онд тус банк үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийг гүйлгээнд гаргаж мөнгөний эргэлтийн эмх замбараагүй байдал, олон төрлийн мөнгөний гүйлгээг зогсоож чадсан байна. Тэрчлэн Монголбанк гадаад, дотоодын худалдаа, аж ахуйн газруудыг санхүүжүүлж худалдаа, гүйлгээнд хяналт тавих, зохицуулах үүргийг гүйцэтгэсэн байна.

1935 онд ЗХУ, Монголын худалдаа, аж үйлдвэрийн банкиг анх байгуулахад оруулсан өөрийнхөө хувь хөрөнгийг БНМАУ-д шилжүүлэн өгчээ. 1954 оны нэгдүгээр сарын 1-нээс Монголын Худалдаа-аж үйлдвэрийн хувь нийлүүлсэн банкиг БНМАУ-ын улсын банк болгон өөрчлөн байгуулсан байна.



МОСКВАГИЙН ЗААВАР

Орос Монголын банк байгуулах тухай БХК(б)Н-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хурлын протокол. 1923 он.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

МАРШЛЫН ОДОН
БНМАУ-ЫН МАРШАЛЫН ОД
Он: 1979

Жин: 80 гр, голч: 6 см

"Маршалын од" нь шижир алт бөгөөд тал бүр тийшээ цацарсан таван хошуу хэлбэртэй юм. Таван хошууны төв дунд төрийн сүлдийг цагаан алтаар товойлгож дүрсэлсэн байна.

Одны хошууд хооронд 5 ширхэг очир алмаазыг цагаан алтаар хүрээлж шигтгэсэн. 14.5 грамм цагаан алт, 54.1 грамм шар алт, 4.9 карат очир алмаз чулуу оржээ.

Алтан бэхэлгээгээр гурвалжин алтан сэнжтэй холбогдож, түүнээс төрийн далбааны өнгөтэй 3.5 см-ийн өргөн торгон туузаар сүвлэсэн байна.





МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС (2019.01.24)

Монголбанкны сар тутмын ээлжит хэвлэлийн бага хурал нэгдүгээр сарын 24-ний өдөр боллоо. Хэвлэлийн хурлын үеэр сэтгүүлчдийн тавьсан асуултад Монголбанкны газрын захирлууд хэрхэн хариулсныг хүргэж байна.

Блүүмбэрг ТВ:

Инфляцийн дүн гарсан. Улаанбаатар хотын хэмжээнд 10 орчим хувьд хүрээд байна. Энэ онд Засгийн газар цалин, тэтгэврийг нэмэх замаар эрэлтийг нэлээд нэмэгдүүлэхээр байна. ОУВС-аас ч бас 2019 оны хувьд инфляцийн гол сорилт нь дотоод эрэлт болж байна гэж мэдэгдсэн. Тэгэхээр Засгийн газрын бодлого инфляцид ямар дарамт учруулах вэ?

Мөнгөний бодлогын газрын захирал **Б.БАЯРДАВАА**:

Инфляци улсын хэмжээнд 8.1 хувьтай гарсан. Улаанбаатар хотын хэмжээнд тооцож үзвэл 9.7 хувьтай байгаа. Бидний хувьд инфляцийн гүйцэтгэлээс гадна ирээдүйн төлөв байдлыг харж, бодлогын шийдвэрүүдээ гаргадаг. Энэ нь мөнгөний бодлогын аливаа шийдвэр тодорхой хугацааны хоцрогдолтойгоор эдийн засагт бодит нөлөөллөө үзүүлдэгтэй холбоотой. Тэгэхээр өнөөдөр гаргасан шийдвэр 4-6 улирлын дараа нөлөөлөл нь гарч эхэлнэ. Хамгийн сүүлд 11 дүгээр сард бодлогын хүүг нэмэгдүүлсэн. Үүнд олон хүчин зүйлийг харгалзан үзсэн. Нэгдүгээрт, гадаад нөхцөл байдал тодорхой бус хэвээр байна. Эдийн засгийн дотоод идэвхжил маш өндөр хурдтай явагдаж, инфляци зорилтот түвшний орчимд ойрхон ирсэн зэрэг хүчин зүйлийг харгалзан үзсэн. Мэдээж Улаанбаатар хотын инфляци 9.7 хувьд

хүрсэн нь өндөр үзүүлэлт. Гэхдээ үүний шалтгааныг харвал улирлын шинж чанартай нөлөөлөл маш хүчтэй байгаа. Тухайлбал, махны үнийн өсөлт нийт 9.7 хувийн инфляцийн 1.7 хувийг дангаараа тайлбарлаж байгаа. Махны үнийн тухайд 12 дугаар сараас эхлээд тавдугаар сар хүртэл үнэ нь өсдөг улирлын онцлогтой. Нөгөө талаас гэр хороололд хэрэглэж байгаа түлээ, нүүрсний үнийн өсөлт нийт инфляцийнхаа 2.4 нэгж хувийг эзэлж байгаа. Мөн л улирлын онцлогтой бүтээгдэхүүн. Тодруулбал, улирлын шинж чанараасаа хамаараад 10, эсвэл 11 дүгээр сарын аль нэг үеэс нь эхлэн үнэ нь өсдөг. Гуравдугаар сараас үнэ нь тогтворжиж, буурч эхэлдэг улирлын хандлагатай. Өнгөрсөн 2018 оны тухайд хатуу түлшний үнэд улирлын онцлогтой үнийн өсөлт ажиглагдсан ч эргээд буурах үзэгдэл ажиглагдаагүй. 2018 оны 10 дугаар сар хүртэл үнэ өссөн түвшин хэвээр хадгалагдаж байгаад 11 дүгээр сараас үнэ нь өссөн. Улмаар 12 дугаар сард бүр огцом өссөн байгаа. Үүнээс гадна дотоодын зах зээл дээр борлуулагдаж байгаа бензин, түлшний үнэ 1.3 нэгж хувийг нь эзэлж байна. Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ өссөнтэй холбоотойгоор дотоодын бензин, шатахууны үнэ нэлээд өссөн. Одоо эргээд буурсан учраас нөлөөлөл нь нэгдүгээр сарын эцсийн инфляцид орж ирснээр, Улаанбаатар хотын инфляци 1 дүгээр сард 9 орчим

хувьтай гарах болов уу гэж хүлээж байгаа.

Үүнээс гадна бидний байнга анхаарч байдаг нэг зүйл нь инфляцийн суурь хандлага юм. Эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотойгоор инфляцийн өсөлт цаашид хурдсах суурь нөхцөл байна уу, үгүй юу гэдгийг харж байна гэсэн үг. Одоохондоо ийм дарамт харьцангуй бага байна. Гэхдээ нийлүүлэлтийн болон улирлын шинж чанартай бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бусад бараа, бүтээгдэхүүний үнэд нөлөөлж, инфляцийг хөөрөгдөх эрсдэл байдаг. Үүнийг бид инфляцийн тухайлсан бараа, бүтээгдэхүүний хоёр дахь үеийн нөлөө гэдэг. Үүнээс урьдчилан сэргийлэх шаардлага бий. Энэ бүгдийг бид анхааралтай ажиглаж, цаашдын шийдвэрүүдээ гаргах болно.

Блүүмбэрг ТВ:

Төв банкны хараат бус байдал хэр түвшинд байна вэ. Ялангуяа сонгууль дөхөж байгаа үед төв банкны хараат бус байдал руу халдах гэсэн оролдлогууд гарах магадлал нэмэгдэх тал байдаг. Энэ асуудлаар та бүхэн ямар байр суурьтай байна вэ? Хараат бус байдлыг хэрхэн сайжруулах вэ?

МБГ-ын захирал Б.БАЯРДАВАА:

Төв банкны хараат бус байдлын тухайд хамгийн сүүлд 2016 онд хийсэн хөндлөнгийн судалгааны үр дүн бий. Үүгээр хараат бус байдлын индексийг 100 хувь гэж үзвэл Монголбанкны хувьд 50-60 хувьтай байна гэсэн үр дүн гарсан. Үүнээс хойш судалгаанууд шинэчлэгдээгүй байна. Гэхдээ судалгааны үр дүнд үндэслээд, хараат бус байдалд нөлөөлж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Төв банкны тухай хууль, Банкны тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үүн дотроо хамгийн чухал өөрчлөлт нь мөнгөний бодлогын шийдвэр хороогоор дамжиж гардаг болсон. Хороонд төв банкны гурван ерөнхийлөгч, гаднаас томилогддог дөрвөн гишүүн бий. Хорооны хурлаар, мөнгөний бодлогын хүүг бууруулах, өсгөх эсвэл макро зохистой бодлогын шийдвэрүүдийг гаргаж байгаа. Ингэхдээ олонхийн санал, зөвшилцөлд үндэслэж, хөндлөнгийн, хараат бус гишүүдийн оролцоотойгоор шийдвэрийг гаргаж байна. Энэ бол төв банкны хараат бус байдлыг үлэмж хэмжээгээр дээшлүүлсэн арга хэмжээ болсон. Ханштай холбоотойгоор олон нийтийн дунд төв банкиг шүүмжлэх хандлага бий. Төв банкны тухай хуулийн 4.1 дэх заалтад төв банкны зорилгыг төгрөгийн тогтвортой байдал гэж тусгасантай холбоотой. Өнгөрсөн

удаад Төв банкны тухай хуулийн өөрчлөлтөөр энэхүү заалтыг “Үнийн тогтвортой байдал” болгож өөрчлөх саналыг тусгасан боловч Их хурал дээр дэмжлэг авч, батлагдаагүй. Тэгэхээр Төв банкны үндсэн зорилгыг “Үнийн тогтвортой байдал” гэж тусгах нь цаашдаа Төв банкны хараат бус байдлыг дээшлүүлэхийн тулд зайлшгүй хийгдэх ёстой хуулийн зохицуулалт юм.

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал А.ЭНХЖИН:

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн талаар товчхон мэдээлэл өгье. Он гарснаас хойш төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.3 хувиар чангарсан байна. Тэгэхээр энэ нь дотоодын валютын зах дээр ам.долларын эрэлт, нийлүүлэлт тогтвортой байна. Төгрөгийн ханшид хүчтэй нөлөөлөх хүчин зүйл ажиглагдахгүй байгаатай холбоотой. Гэхдээ төгрөгийн ам.доллартай харьцах ханш манай улсын экспортын гол түүхий эдийн үнэ, хэмжээнээс ихээхэн хамааралтай. 2018 онд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 8.9 хувиар сулрахад дотоод, гадаад хүчин зүйл нөлөөлсөн гэдгийг төв банкнаас өмнө нь мэдэгдэж байсан.

Гадаад хүчин зүйлсийн хувьд АНУ-ын Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ үргэлжлүүлэн нэмэгдүүлсэн нь ам.долларын суурь хүүг өсгөсөн. Томоохон эдийн засагтай улсуудын хооронд өрнөж байгаа худалдааны дайнтай холбоотойгоор манай улсын экспортын гол түүхий эд болох зэсийн үнэ 2018 онд буурсан. Нөгөө талдаа манай улсын импортын гол түүхий эд болох нефть бүтээгдэхүүний үнэ багагүй хувиар нэмэгдсэн нь төлбөрийн тэнцэлд дарамт учруулсан.

Дотоод хүчин зүйлийн тухайд эдийн засгийн идэвхжил нэмэгдсэнтэй холбоотойгоор импорт өссөн. 2018 онд импорт 36 хувиар өссөнийг та бүхэн сая танилцуулга дээрээс харсан байх. Валютын ханшид дарамт учруулсан өөр нэг хүчин зүйл нь 2018 онд Засгийн газар, Хөгжлийн банкнаас нийт 570 сая ам.долларын зээлийн үйлчилгээ хийгдсэн байна. Энэ нь ханшид тодорхой хэмжээгээр дарамт учруулсан. 2019 он гарсаар валютын ханш тогтворжиж байгаа нь хэд хэдэн шалтгаантай. Нэгдүгээрт, Төв банкны Мөнгөний бодлогын хорооны 2018 оны 11 дүгээр сарын 27-ны хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 11 хувьд хүргэсэн. Энэ нь төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлж, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй арга хэмжээ болсон. 2019 оны

нэгдүгээр сарын 1-нээс хэрэглээний зээлийн өсөлтийг хязгаарлахад чиглэсэн макро зохистой бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлсэн. Ингэснээр хэрэглээний зээл тодорхой хэмжээгээр буурч, хэрэглээний импортыг бууруулах нөлөө үзүүлнэ. Энэ нь мэдээж ханшид эерэг нөлөө үзүүлнэ. Үүнээс гадна бидний харж байгаа бас нэг эерэг нөлөө нь ЗГ, Хөгжлийн банкнаас 2019 онд хийгдэх томоохон төлбөрүүд байхгүй. Бидний тооцоолсноор энэ онд 200 хүрэхгүй сая ам.долларын зээлийн үйлчилгээний төлбөр хийгдэнэ гэсэн хүлээлттэй байна. Түүнчлэн Монгол Улсыг чиглэсэн валютын урсгал 2018 онтой харьцуулахад 2019 онд нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байна. 2018 онд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд 439 сая ам.доллар Монгол Улсад орж ирсэн бол 2019 онд бидний тооцоолсноор 800 сая ам.доллар орж ирэхээр хүлээгдэж байна. Өөр нэг эерэг мэдээ нь өчигдөр Монголын Ипотекийн Корпорациас 250 сая ам.долларын бондыг олон улсын санхүүгийн зах зээлд амжилттай гаргасан байна. Мөн Засгийн газрын бодлогын хүрээнд Тавантолгойн IPO амжилттай хийгдвэл ханшид эерэг нөлөө үзүүлнэ. 2019 оны хувьд Монгол Улсыг чиглэх валютын урсгал сайн байна гэж бид үзэж байна.

Ийгл ТВ:

12 дугаар сард ипотекийн зээл олголт эрс буурсан гэж байна. Энэ нь банкуудын өөрсдийн бодож олсон шийдвэр юм уу, эсвэл Засгийн газар, Монголбанкны түвшинд зээлийн хэмжээг бууруулах бодлого баримталж байгаа юм уу?

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал **А.ЭНХЖИН:**

2018 оны 12 дугаар сард нийт 1152 зээлдэгчийн 100 тэрбум төгрөгийн ипотекийн зээлийг банкууд олгосон байна. Үүнд мэдээж ипотекийн хөтөлбөрийн зээлээс гадна банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээлүүд орж байгаа. 2018 оны хувьд ипотекийн 8 хувийн хөтөлбөрийн хүрээнд нийт 310 тэрбум төгрөгийн Монголбанк, Засгийн газраас банкуудад олгосон. Үүнд Монголбанкнаас 191.2 тэрбум төгрөг, ЗГ-аас 118.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгосон байгаа. 2018 онд ипотекийн 8 хувийн хөтөлбөрийн хүрээнд нийт 4676 зээлдэгчийн ипотекийн зээлийг санхүүжүүлсэн байна. Засгийн газраас 2018 оны арванхоёрдугаар сарын 5-ны өдөр Ипотекийн хөнгөлөлттэй зээлийн журмыг баталсан. Уг журмын дагуу зээлдэгчид тавих зарим шаардлагыг өөрчилсөн. Мөн санхүүжилтийн хүүг

бууруулах замаар арилжааны банкуудын эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх шинжтэй өөрчлөлтүүд орсон байгаа. Монголбанк, ЗГ, БХБЯ-наас холбогдох ажлын хэсэг гараад, Засгийн газрын баталсан журмыг одоо хэрэгжиж байгаа журамтай хэрхэн нийцүүлэх вэ гэдэг дээр ажиллаж байна. Монголбанкны хувьд яг өнөөдрийн байдлаар хөтөлбөрийг хэвийн үргэлжлүүлж байгаа. Монголбанкнаас ипотекийн зээлийн эргэн төлөлтөөс 16 тэрбум төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгодог. Нэгдүгээр сард энэ хэмжээний санхүүжилт олгогдоно. Засгийн газрын хувьд ипотекийн санхүүжилтийг улирлаар нь хийдэг. Нэгдүгээр улирлын санхүүжилт одоогоор хийгдээгүй байна. ЗГ-ын санхүүжилт хийгдэхээс өмнө бид ЗГ-ын шинэ журамд одоо мөрдөж байгаа журам, заавар, гэрээнүүдээ нийцүүлж, ЗГ-ын шинэ журмыг хэрэгжүүлж эхэлнэ гэсэн төлөвлөгөөтэй байна. Шинэ журмыг хэрэгжүүлэхэд бас нэг зайлшгүй анхаарах ёстой зүйл нь Монгол Улсын ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд тодорхой үүргүүдийг хүлээсэн. Тэгэхээр ЗГ-ын шинэ журмын хэрэгжилтийн тал дээр ОУВС-тай зөвшилцөх шаардлага бий. Үүнийг тодорхой болгосны дараа шинэ журмыг хэрэгжүүлнэ.

C1 телевиз:

Зээлийн хүүг бууруулах асуудлаар Монголбанк ямар байр суурьтай байгаа вэ. УИХ дээр зээлийн хүүнд хязгаар тогтоох хуулийн төсөл дэмжигдсэн байгаа шүү дээ?

Судалгаа, статистикийн газрын захирал **Д.ГАН-ОЧИР:**

Зээлийн хүүг бууруулах асуудлаар Монголбанкны байр суурь маш тодорхой. Монголбанк Зээлийн хүүг бууруулах стратеги, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр батлуулсан. Энэ хүрээнд Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо холбогдох арга хэмжээнүүдийг авах замаар зах зээлийн суурь зарчимтай нийцсэн, суурь нөхцөлийг нь бүрдүүлэх замаар зээлийн хүүг бууруулна. Түүнээс биш зээлийн хүүний дээд хязгаар тогтоох, эсвэл аливаа захиргаадалтын арга хэмжээ авах нь гадаадын хөрөнгө оруулагчдад сөрөг мэдээ болж, дотоод зах зээлийг гажуудалд оруулах арга хэмжээ авах шаардлагагүй. Энэ нь эргээд анхны зорилт буюу жижиг, дунд үйлдвэрлэгчдэд очих зээлийн хүүг бууруулахаасаа илүү сөрөг нөлөө авчрах, санхүүгийн зуучлалыг хумьж, санхүүгийн салбарын эмзэг байдлыг

нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа. Төв банкны байр суурь бол зээлийн хүүний дээд хязгаар тогтоох шаардлагагүй. Макро тогтвортой орчныг бий болгож, зах зээлийн суурь зарчимтай нийцсэн байдлаар зээлийн хүүг бууруулах боломжтой гэж үзэж байгаа. Миний дээр дурдсанчлан 2018 онд зээлийн дундаж хүү 2.3 нэгж хувиар буурч, 16.9 хувьд хүрсэн. Тэгэхээр зээлийн хүү нь бодлогын хүү, зах зээлийн суурь нөхцөлөө дагаад буурч болдог гэдгийг бид бүхэн харж байна. Цаашдаа валютын ханш, инфляци тогтвортой байж, эдийн засгийн таатай суурь нөхцөл маань хадгалагдвал, зээлийн хүү үргэлжлэн буурах боломжтой.

C1 телевиз:

Сүүлийн үед олон нийтийн сүлжээнд “Монголбанкны ажилтнуудын дунд банк бус санхүүгийн байгууллагатай маш олон хүн бий. Тийм учраас хүүг бууруулах, мөнгө хүүлэлттэй тэмцэх асуудалд хойрго хандаж байна” гэх шүүмжлэл өрнөх болсон. Үнэхээр тийм олон хүн банк, бус санхүүгийн байгууллагатай юм уу?

Хууль эрх зүйн газрын захирал Д.АЮУШ:

Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн дагуу Монголбанкны ахлах мэргэжилтэн болон түүнээс дээш албан тушаалтнууд нь нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлгийг өгч, АТГ-аас санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр томилогддог. Хуулиар шууд аж ахуйн нэгж, байгууллагад хөрөнгө оруулахыг хориглосон зохицуулалт байхгүй. Гэхдээ одоогийн томилогдсон байгаа хүмүүсийн дунд АТГ-аас ашиг сонирхлын зөрчилтэй гэх асуудал гараагүй. Нөгөөтэйгүүр Монголбанкны дотоод хяналтын систем маш сайн ажилладаг. Мөн Монголбанкны Хөдөлмөрийн дотоод журам гэж бий. Үүнд ашиг сонирхол үүсэхээр ямар нэгэн аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгө оруулах, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад оролцохоос сэргийлэх тухай зохицуулалт бий. Түүнчлэн Монголбанкны ажилтны ёс зүйн дүрэм батлагдсан. Энэ дүрэмд ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой нэлээд олон зохицуулалтыг оруулж өгсөн. Өөрөөр хэлбэл, Монголбанкнаас хяналт, шалгалт хийдэг аж ахуйн нэгж, байгууллагын нөлөө бүхий хувьцаа, санхүүгийн үүсмэл хэрэгсэлд хөрөнгө оруулахаас татгалзах ёстой. Мөн ёс зүйн маргаан таслах комисс гэж Монголбанкинд ажилладаг. Энэхүү комисс нь улирал тутамд санал, гомдлыг хүлээн авч, холбогдох дүгнэлтийг гаргадаг. Үнэхээр Монголбанкны ажилтны зүгээс ашиг сонирхлын

зөрчил гаргасан аливаа үйлдэл хийсэн бол хэн ч энэ комисст хандан шалгуулах эрхтэй. Мөн Дотоод аудитын газраас энэ асуудал хяналт тавьж ажилладаг.

Монгол ТВ:

Активын чанарын үнэлгээний дагуу 2018 онд банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлэх даалгавар авсан. Өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үйл явц ямар байна вэ?

Хяналт, шалгалтын газрын захирал Н.БАТСАЙХАН:

Монголын банкны системд активын чанарын үнэлгээ хийгдэж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх үүрэг өгсөн. 2018 оны туршид банкууд нийтдээ 505.4 тэрбум төгрөгөөр өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн. Зарим хэлцэл он дамжаад, ойрын хугацаанд бүрэн хийгдэж дуусна.


БЛҮҮМБЭРГ ТВ:

Гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.5 тэрбум ам.долларт хүрсэн гэж байна. Үүний хэдэн хувь нь Оюутолгойн хөрөнгө оруулалт вэ. Ер нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын төвлөрлийн талаар мэдээлэл өгнө үү.

ССГ-ын захирал Д.ГАН-ОЧИР:

Гадаадын шууд хөрөнгө оруулалт сүүлийн 5 жилд байгаагүй өндөр түвшинд хүрсэн нь сайн хэрэг. Гэхдээ бид хөрөнгө оруулалтын төвлөрлийн асуудалд анхаарах шаардлага бий. Монголын хувьд бүхэлдээ уул уурхайн салбарт чиглэсэн хөрөнгө оруулалт болж байгаа. Уул уурхай дотроо томоохон компаниуд буюу мега төслүүдэд 90 орчим хувь нь дангаараа орж ирж байгаа юм. Тэгэхээр одоогийн явж байгаа томоохон мега төслүүдийн хөрөнгө оруулалт 2020, 2021 онд дуусгавар болно. Тэр үед гадаадын шууд хөрөнгө оруулалт нам зогсох уу, хөрөнгө, санхүүгийн урсгалыг татраах уу гэдэг эмзэг байдлыг бий болгож байгаа. Тэгэхээр бид бүхэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох бүтцийн бодлого дээрээ үргэлжлүүлэн анхаарах шаардлага бий. Энэ бол экспортын төрөлжилт, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох талаасаа зайлшгүй хийх ёстой зүйл. Үүний эх үүсвэр нь дотоод гэхээсээ илүү гадаадаас орж ирэх ёстой, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалт байх ёстой. Энэ утгаараа бодлого боловсруулагчдын хувьд 2020, 2021 он хүртэл бодож төлөвлөх, хийх зүйл маш их байгаа гэдгийг онцолмоор байна.

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц




- **M2 мөнгөний жилийн өсөлт 22.8%** -д хүрч **19.5** их наяд ₮-т хүрэв.
- Өмнөх сараас **4.4%**-иар буюу **823.4** тэрбум ₮-өөр өсөв.
- Үүнээс, **M1 мөнгө 16.9%** (583.9 тэрбум ₮), **бусад хадгаламж 1.6%** (239.5 тэрбум ₮) –иар өссөн байна.
- **M1** → ₮-ийн харилцах **528.5** тэрбум ₮-өөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө **55.5** тэрбум ₮-өөр өсөв.
- **Бусад хадгаламж** → ₮-ийн хадгаламж **514.4** тэрбум ₮-өөр, \$-ийн хадгаламж **100.5** тэрбум ₮-өөр өсч, \$-ийн харилцах **375.4** тэрбум ₮-өөр буурав.

Зураг 1.2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Зураг 2.3. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл **17.1** их наяд ₮ (₮ зээл **14.4** их наяд ₮, \$ зээл **2.7** их наяд ₮)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **506** тэрбум ₮ буюу **3%**-иар өссөн.
- Хэвийн зээл өмнөх сараас **915** тэрбум ₮ буюу **7%**-иар өссөн.
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **125** тэрбум ₮ буюу **13%**-иар буурсан.
- Чанаргүй зээл өмнөх сараас **283** тэрбум ₮ буюу **14%**-иар буурсан байна.

Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар




Зураг 3.3. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр




- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн **75.0%** нь хөтөлбөрийн зээл, **22.9%** нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, **2.1%** нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Орон нутгийн ипотекийн зээл-ийн **78.2%** нь хөтөлбөрийн зээл, **20.9%** нь өөрийн эх үүсвэрээр, **0.9** нь бусад эх үүсвэрээр олгогджээ.


Зураг 3.4. Ипотекийн зээлийн үлдэгдэл аймгуудаар



Зураг 4.3. Нийт хадгаламжийн үлдэгдэл, хүү




Зураг 4.4. Нийт зээлийн үлдэгдэл, хүү




- Иргэдийн ₮-ийн хадгаламжийн ЖДХ 12.0%, хувийн байгууллагын ₮-ийн хадгаламжийн ЖДХ 11.4%-тай байна.
- Иргэдийн ₮-ийн зээлийн ЖДХ 18.0%, хувийн байгууллагын ₮-ийн зээлийн ЖДХ 15.5%-тай байна.


5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2018 оны эхний 11 сар



Зураг 6.5. Валютын ханшийн талаарх хүлээлт



Зураг 6.6. Зээлийн хүүний талаарх хүлээлт



- Валютын ханшийн хүлээлтийн чиглэлийн индексээс харахад 2017 оны I улирлаас эхлэн иргэд, ААН-ийн хувьд төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт нэмэгдсэн,
- Харин 2018 оны IV улиралд явуулсан судалгаагаар иргэд болон ААН-ийн дунд **төгрөгийн ханш суларна** гэсэн хүлээлт бага зэрэг нэмэгдлээ.

- Иргэд, ААН-ийн дийлэнх нь ирэх 12 сарын хугацаанд **зээлийн хүү хэвэндээ** байна гэсэн хүлээлттэй байна.



“БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАДГАЛАХАД ЧИГЛЭСЭН РЕФОРМУУДАА ЦААШ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ НЬ ЧУХАЛ”

Азийн Хөгжлийн банкны Монгол дахь суурин төлөөлөгч Ёланда Фернандез Ломментай ярилцлаа.

Та 2018 оны Монгол Улсын эдийн засгийг хэрхэн дүгнэж байна вэ?

2018 он гайхалтай жил байлаа. ДНБ-ний өсөлт, түүний гүйцэтгэл 2018 оны эхэнд хийгдэж байсан бүх төсөөллийг давснаас гадна, төсвийн тал дээр томоохон ахиц гарсан нь гайхалтай юм. Ялангуяа, би төсвийн гүйцэтгэл болон төсөв ашигтай гарсанд өндөр сэтгэгдэлтэй байна. Энэ нь томоохон ахиц бөгөөд учир нь хэдхэн жилийн өмнө тус улсын эдийн засаг хүндэрч, ДНБ-ний өсөлт саарч, төсвийн алдагдал ихэссэн зэрэг макро эдийн засгийн бусад үзүүлэлтүүд бүгд тогтворгүй байсан. Тиймээс эдийн засаг богино хугацаанд сэргэж, төсвийн нөхцөл байдал сайжрахын хамт өсөлтийн буюу зөв голдиролдоо орлоо.

Энэ бүхэн ОУВС-ийн

хөтөлбөрийн тусламжтай бий болсон ба энэ нь мөн төсвийн тэнцвэржүүлэлт зэрэг эдийн засгийн хэт өсөлтийг хязгаарлах, хөргөх нөлөө үзүүлдэг.

Тэгвэл 2019 оныг хэрхэн төсөөлж байна вэ?

2019 оны эдийн засгийн төлөв мөн л эерэг байх хандлагатай байна. Яг одоо бид цаашдын төсөөлөл, тооцоон дээрээ ажиллаж байгаа. 4-р сарын эхээр зарлагдах болно. Бид энэ жил ДНБ-ний өсөлтийг 6 орчим хувь байхаар харж байгаа. Энэ нь тогтвортой буюу эрүүл өсөлт байх юм.

2019 онд анхааралтай ажиглах ёстой зүйлсийн нэг нь яах аргагүй түүхий эдийн үнэ юм. Энэ жил нүүрсний үнийн өөрчлөлт ямар байх бол?

Эдийн засагт нөлөөлөх гадаад

хүчин зүйлсийн төсөөллийг гаргахад ихээхэн хүндрэл учирдаг. Одоогийн байдлаар түүхий эдийн үнийн трендэд томоохон өөрчлөлт гарна гэж бид харахгүй байна. Мэдээж, маш олон тодорхойгүй байдал оршсоор байна. Дэлхийн эдийн засаг худалдааны тал дээр томоохон асуудлуудтай тулгарчихсан байна. Худалдааны хоригууд нэмэгдэх нь дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлнө. Гэхдээ Монгол Улсын эдийн засгийн төлөв эерэг байна.

Нүүрсний хувьд Монгол Улсын гол экспортын бүтээгдэхүүний нэг бөгөөд, анхаарч байвал зохих зүйл бол БНХАУ-ын зүгээс нүүрсэнд тавьж болзошгүй хязгаарлалт юм. Гэхдээ 2018 онд нүүрсний экспорт харьцангуй сайн байсан. Мөн түүнээс гадна анхаарвал зохих өөр нэг зүйл бол гадаадын шууд хөрөнгө оруулалт юм. Энэ нь

2018 онд 2 тэрбум ам.долларыг давсан ба 2019 өндөр хэвээр байх хандлагатай байна.

Монгол Улсад ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжиж байгаа. Монголбанкны зүгээс тохиролцсондоо хүрэхийн тулд идэвхтэйгээр ажиллаж байна. Төв банкны зүгээс ялангуяа, банкны салбарын реформыг эхлүүлсэн бөгөөд 2019 онд юун дээр анхаарвал зохих вэ?

Банкны салбарын хувьд Монголбанкнаас 2018 онд хэрэгжүүлж байсан санаачилга, бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зохимжтой болов уу. Ялангуяа, тус салбарт хийгдсэн активын чанарын үнэлгээ бол маш чухал ажил байсан. Үнэлгээний үр дүн бидний төсөөлж байснаас илүү эерэг гарсан байгаа. Гэхдээ цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад шаардлагатай чухал реформуудыг хийх нь зүйтэй. Учир нь банкны салбар нь эдийн засагт чухал үүргийг гүйцэтгэдэг. Хэрэв тус салбар хүндэрвэл, эдийн засагт маш их хөнөөл учруулах болно. Тиймээс зохицуулалтын орчинг үргэлжлүүлэн сайжруулж, чанаргүй зээлийн түвшинг анхааралтай хянаж, бодит эдийн засагт нөлөөлөх буюу орлого, өсөлтийг муутгаж болзошгүй тогтворгүй байдлаас сэргийлэх нь зүйтэй юм.

Монголбанк макро зохистой бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй болсноор хэрэглээний зээлийн өр орлогын харьцааг 70%-д, хугацааг дээд тал нь 30 сар байхаар тогтоож өгсөн. Хэрэглээний зээл сүүлийн хугацаанд их хэмжээгээр өсч байгаа нь энэхүү арга хэмжээг

авахад хүргэсэн. Хэрэглээний зээл өсөх нь богино хугацаанд эдийн засгийг дэмжих хэдий ч, дунд урт хугацаанд эрсдэлийг нэмэгдүүлэх аюултай байдаг. Та үүнийг хэрхэн харж байна вэ?

Банкны болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгална гэдэг маш чухал. Банкны зээл өснө гэдэг нь нийт эрэлтээр дамжуулж эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг. Гэхдээ хэт өсч, стандарт хэмжээнээс давах юм бол зээл нь эдийн засагт тогтворгүй байдлыг бий болгодог. Тиймээс олон улсын стандартыг мөрдөж, бусдаас сургамж авч ажиллах нь зүйтэй. Санхүүгийн эдгээр харьцааг санамсаргүйгээр тодорхойлдоггүй бөгөөд ихээхэн тооцоо, шинжилгээн дээр үндэслэж тогтоодог. Тиймээс зээл хэт өсч дунд болон урт хугацаанд асуудал үүсгэхгүй байх нь чухал.

Төв банкны хараат бус байдал, мөнгөний бодлогын орон зайны хувьд маш чухал зүйл шүү дээ. Манай улсын төв банкинд энэ байдал хэр хангагдаж чадаж байна гэж та үзэх вэ?

Хэдхэн жилийн өмнөхтэй харьцуулбал нөхцөл байдал тогтворжоод байгаа. Өөрөөр хэлбэл, 2015 онд мөнгөний нийлүүлэлт тогтворгүйгээр өсч, инфляцийн дарамтыг бий болгож байсантай харьцуулбал өнөөдөр мөнгөний бодлогын нөхцөл байдал тогтворжсон. Мөн саяхан бодлогын хүүг өсгөх шийдвэр гаргасан нь инфляцийн эсрэг авсан чухал арга хэмжээ юм.

Та Монгол Улсад багагүй хугацаанд ажиллаж байна. Банкны салбарын хөгжил болон цаашид ямар эрсдэлүүд оршиж байна гэж харж байгаа вэ?

Би Монголд 2001 оноос хойш ажиллаж байна. Тэр цагаас хойш тус улсын эдийн засаг бүх салбарт хурдацтайгаар хөгжсөн. Энэ хөгжилд банкны салбар ч хамаарах ба илүү нарийсан, цаг үетэйгээ нийцэж, боловсронгуй болоод байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Сүүлийн үед өсөөд байгаа чанаргүй зээлийг болзошгүй эрсдэл хэмээн үзэж байна. Аль ч улсад чанаргүй зээлийн түвшин бол банкны салбарын эрүүл байдлыг илэрхийлдэг чухал үзүүлэлт. Учир нь чанаргүй зээл хэт өсөх нь банкны салбарын тогтвортой байдлыг алдагдуулж, бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөн, хамгийн муугаар бодоход хямралд хүргэх эрсдэлтэй. Тиймээс түрүүн хэлсэнчлэн зээлийн түвшинг удирдлагадаа байлган, олон улсын зөвшөөрөгдсөн арга хэмжээнүүдийг авч байгаа нь зүйтэй юм.

Та Хятадад ажиллаж байсны хувьд тус улсын эдийн засгийн байдлыг сайн мэдэх хүний нэг гэж үзэж байна. АНУ болон БНХАУ-ын хооронд өрнөөд байгаа худалдааны маргаанд эерэг хүлээлт бий болоод байна. Худалдааны маргаан нь олон улсын эдийн засагт анхаарч байвал зохих чухал хүчин зүйл учраас цаашид хэрхэн өөрчлөгдөх бол?

АНУ болон БНХАУ-ын хооронд хэлэлцээр өрнөхөөр болсон нь чухал юм. Дэлхийн хамгийн том эдийн засгуудад гарах өөрчлөлтүүд нь бусад улс оронд нөлөөлж байдаг. БНХАУ нь Монгол Улсын хөрш, худалдааны томоохон түнш, хөрөнгө оруулагч. Монгол Улсын хувьд БНХАУ тогтвортой байж, эдийн засгийн өсөлт нь эрүүл

” **Банкны салбарын хувьд Монголбанкнаас 2018 онд хэрэгжүүлж байсан санаачилга, бодлогоо үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зохимжтой болов уу. Ялангуяа, тус салбарт хийгдсэн активын чанарын үнэлгээ бол маш чухал ажил байсан. Үнэлгээний үр дүн бидний төсөөлж байснаас илүү эерэг гарсан байгаа. Гэхдээ цаашид санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад шаардлагатай чухал реформуудыг хийх нь зүйтэй.** ”

түвшинд хадгалагдах нь чухал.

Худалдааны маргааны хувьд нөхцөл байдал хоёр талт харилцаанд хүндрэл үүсч, худалдааны хориг эсвэл тариф тавигдаж эхэлсэн өмнөх жилийг бодвол сайжирсан. Худалдааны хоригууд энэ оны 1-р сарын 1-ээс эхлэн хэрэгжихээр байсан ч хэрэгжээгүй нь миний хувьд баяртай байна. Энэ нь хоёр орны хооронд хэлэлцээр хийгдэж эхэлсний үр дүн юм. Тэдгээр орнууд тарифын нөлөөг буруулах арга замыг эрэлхийлж байгаа.

Түүхээс харахад худалдаанд

хориг тавьж байсан нь дэлхийн эдийн засагт хурц хямралыг авчирсан байдаг. Тиймээс худалдааг Дэлхийн Худалдааны Байгууллагын дүрмийн дагуу хийх нь чухал юм.

Худалдааны хувьд ярихад Монгол Улсын худалдааны бодлого тогтвортой байсан удаагүй. Энэ нь төлбөрийн тэнцэлд дарамт учруулж, улмаар валютын ханшид сөргөөр нөлөөлдөг. Үүнийг хэрхэн шийдвэрлэх болох талаар саналаа хуваалцахыг хүсч байна.

Худалдааны бодлого нь Монгол Улсад сорилт болсоор ирсэн. Худалдааны бодлогод томоохон худалдааны түншийн нөлөө зонхилох үүрэгтэй. Ялангуяа, түүхий эдийн экспорт бараг 100% нэг зах зээлээс хамааралтай байгаа нь Монгол Улсыг гадаад орчны өөрчлөлтөд ихээхэн эмзэг болгож байгаа ба үүнийг удирдахад ихээхэн бэрхшээлтэй.

Ихэнх тохиолдолд том улсууд үнийг тодорхойлдог бол, жижиг эдийн засгууд үнийг хүлээн авагч болж байдаг. Жижиг улсад маневр хийх бололцоо хумигдмал байдаг. Тиймээс Монгол Улсад тулгараад байгаа нэг сорилт бол эдийн засгийг төрөлжүүлэх бөгөөд засгийн газраас ч баримталж ирсэн чиглэл энэ юм. Эдийн засгийг хэр сайн төрөлжүүлнэ тэр чинээгээр томоохон түншүүдээс хамааралтай байдал буурч ирдэг. Гэхдээ түүхий эд бол Монгол Улсын эдийн засгийн чухал хэсэг, хувь нэмэр оруулагчийн хувьд экспорт гадаад хүчин зүйлсээс хамааралтай хэвээр байна. Үүнийг том сорилт гэж харж байна.

АХБ нь Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч чухал түнш. Тус хөтөлбөрөөс гадна АХБ-ны зүгээс

Монгол Улсад багагүй ажлуудыг хийж байгаа. Тиймээс АХБ-ны Монгол Улсад хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгнө үү?

Бид олон улсын бусад байгууллагатай хамтран ОУВС-ийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч чухал түнш ч гэлээ, бидний хувьд өөрсдийн хэлэлцээрүүдийг хөтөлбөрөөс гадна, бие даан Засгийн Газартай хийж ирсэн. Бидний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа үргэлж эрэлттэй уялдаатай байдаг. Тиймээс АХБ Засгийн газартай хамтран улс оронд хязгаарлалуудыг бий болгоод байгаа зүйлсийг шийдвэрлэхэд чухал, эрчимтэй яриа хэлэлцээрүүдийг хийдэг. Энэ хүрээнд бид эдийн засгийг төрөлжүүлэх тал дээр ихээхэн идэвхтэй ажиллаж байгаа. Тухайлбал, жижиг дунд бизнесүүд болон газар тариалангийн бизнесүүдийг дэмжих, боловсрол болон эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээг сайжруулах, дэд бүтэц болон харилцаа холбоог хүртээмжтэй болгох тал дээр анхаарах, банкны салбарт дэмжлэг үзүүлэх, бүс нутагт хамтын ажиллагааг хөрш зэргэлдээ орнуудтай дээшлүүлж, зах зээлийн хүрээг өргөжүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлэн, дэмжин ажиллаж байна.

Энд хүрээд бидний ярилцлагын эхний хэсэг өндөрлөж байна. Үргэлжлүүлэн бид та болон таны мэргэжлийн амьдралын талаар ярилцах болно. Хэрэв миний зөв бол та Испаниас гаралтай. Та Испанийн аль хэсэгт төрж, өссөн бэ?

Тийм ээ. Та зөв хэллээ [инээв]. Би Испанийн нийслэл Мадрид хотод, цэргийн дэглэмтэй байх үед

төрсөн. Намайг бага байхад Испани улсад ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжих их хөдөлгөөн өрнөж байсан. Тиймээс, Испанитай ижил төстэй буюу эдийн засаг, улс төрийн талбарт чухал шинэчлэлийг хийсэн Монгол Улс шиг орнууд надад маш дотно санагддаг. Испанийн шилжилтийн үе 70-аад оны сүүлээр эхэлсэн бөгөөд 80-аад онд эрчимжсэн. Энэ үе бол манай улсын хувьд нийгэм, улс төр, эдийн засгийн маш их сонирхолтой өөрчлөлтийг хийж байсан үе.

Испани улс диктатурын дэглэмтэй байсан тул Европын бусад орноос тусгаарлагдаад байсан бөгөөд Евро бүсийн орнуудтай харьцуулахад хөгжлийн хувьд мэдэгдэхүйц хоцрогдоод байсан. Тиймээс, Европын Холбоонд элсэхийн тулд манай улс бүрэн хэмжээний бүтцийн өөрчлөлт, реформыг хийх шаардлагатай болсон. Бид бүгдийн мэдэж байгаачлан эдгээр шинэчлэл сөрөг нөлөө ихтэй бөгөөд манай улсын орчин үеийн түүхэнд ажилгүйдэл, ДНБ-ийн уналт, гиперинфляци гэх мэт маш олон таагүй зүйлсийг туулсан хүнд үе болж үлджээ. Гэхдээ бид (Испани улс) дунд болон урт хугацаанд эдийн засгаа тогтворжуулж, цаашид өндөр стандартыг тогтоон ЕХ-той нэгдэж, дэлхийн эдийн засагтай нягт хамтран ажиллаж, хүрээгээ өргөжүүлж чадсан. Энэ өөрчлөлт намайг залуу байх үед тохиолдсон чухал үйл явдал байсан юм. Магадгүй энэ нь миний эдийн засагч болохоор шийдсэн гол шалтгаануудын нэг. Учир нь үүний үр дүнд би эдийн засаг их сонирхолтой болсон.

Үнэндээ би Танаас энэ асуулыг яг асуух гэж байлаа. Та яагаад эдийн засагч болохоор

шийдсэн бэ?

Би олон мэргэжил дундаас макро эдийн засагч болохоор шийдсэн. Учир нь макро эдийн засагч эдийн засагт нэг дор тохиолдох олон үйл явдлыг бүхлээр нь ойлгож, шинжилгээ хийж чаддаг. Магадгүй, макро эдийн засагч болсноор тодорхой салбараар нарийн мэргэшдэггүй ч тогтолцоог бүхлээр нь хэрхэн ажиллаж байгааг эсвэл аль нэг салбар хүндэрвэл юу болохыг том дүр зургаар ойлгодоггоороо давуу талтай юм. Мөн мөнгөний бодлого эсвэл төсвийн бодлогод өөрчлөлт гарах үед эдийн засагт үзүүлэх нөлөөллийг мэдэх боломжтой. Ингэснээр системийг бүхлээр нь буюу шаардлагатай бүх уялдаа холбоосыг бүргэдийн нүдээр харах боломжийг олгодог. Үнийг би гайхалтай зүйл гэж бодсон. Тиймээс ч би энэ чиглэлд мэргэшиж, докторын зэргээ макро эдийн засгаар хамгаалсан.

Та докторын зэргээ Хятадын эдийн засаг сэдвээр хамгаалсан. Яагаад та энэ сэдвийг сонгосон бэ?

Тийм ээ, манай оронд тохиолдсон үйл явдалтай ижил төстэй байсан тул Хятад миний сонирхлыг татсан. БНХАУ-ын эдийн засгийн өөрчлөлт тэр дундаа тэдний хүрсэн үр дүн, сая сая хүн ядуурлаас ангижирсан явдал нь сэтгэл татам юм. Хятад улсын эдийн засгийн шинэчлэл нь маш богино хугацаанд хийгдсэн бөгөөд өөрчлөлтийг сууриар нь хийж чадсан нь мөн л гайхалтай байсан. Би бас өөрийн төрөлх оронтой ижилсгэж харсан. Тиймээс ч БНХАУ-ын эдийн засгийн өөрчлөлтөд анхаарлаа төвлөрүүлэхээр шийдсэн юм.

Таны докторын ажлын үр дүн юу байсан бэ?

Би докторын зэргээ Хятадын эдийн засгийн өсөлтийн хүчин зүйлс болон эх үүсвэр сэдвээр төвлөрөн хамгаалсан. Энэ хүнд хэцүү шинэчлэлийг хийж байхад Хятад Улсын эдийн засаг яаж жил бүр 10-аас дээш хувиар өсч байгааг дэлхий даяараа сонирхож, ойлгохыг хичээж байсан. Мэдээж хэрэг докторын ажил нь маш өндөр төвшний техник ажиллагаа шаарддаг бөгөөд би Хятадын эдийн засгийн өсөлтийн чиглүүлэгчдийг хэмжих, тодорхойлох арга замыг олохыг хүсэж, цаашлаад тэдгээр нь Хятад улсын эдийн засаг амжилтад хүрэхэд хэрхэн хувь нэмэр оруулсныг тодорхойлохыг хүссэн. Тиймээс, миний судалгааны арга зүй өсөлтийн эх үүсвэрт эконометрик анализ хийх байсан юм. Үр дүн нь төдийлөн цочирдмоор байгаагүй. Хятадын ДНБ-ийн өсөлтөд эдийн засгийг нээлттэй болгосон, экспортын бодлого чиглэлийг тодорхойлсон, экспортын өсөлтийг нэмэгдүүлсэн, гадаадын хөрөнгө оруулалтыг оруулж ирсэн зэрэг нь нөлөөлсөн байдаг.

Та Хятадад хэдэн жил ажилласан билээ?

Би амьдралынхаа янз бүрийн үе шатанд Хятадад ажиллаж байсан. Докторант оюутан байхдаа би диссертацийн судалгааны ажлын хүрээнд тогтмол очдог байсан. Дараа нь би Испанид Азийн, ялангуяа Хятадын эдийн засагт төвлөрсөн тинк танкийн ажлын шугамаар мөн ажилласан. Тиймээс би Хятад руу байнга явдаг байж. Сүүлд би АХБ-нд ажиллаж байхдаа Бээжин хот дахь АХБ-ны эдийн засгийн албаны даргын албыг 5

орчим жил хашиж байсан.

АХБ бол Азид нөлөө бүхий байгууллага. Гэхдээ энэ байгууллагад ажиллахад танд юу нөлөөлсөн бэ?

Тинк танк ажлын маань хүрээнд намайг Австрийн Сальцбург хотод зохион байгуулсан олон улсын томоохон чуулга уулзалтад оролцохыг урьсан юм. Азийн эдийн засгийн сэдэвтэй уулзалт байсан тул Азиас олон хүн ирж, дэлхийн өнцөг булан бүрээс энэхүү чуулганд оролцсон. 20 жилийн өмнөх тэр үед Азийн улс орнууд хурдацтай өөрчлөгдөж, хөгжиж эхэлж байсан бөгөөд хүн бүр яагаад Азийн улс орнууд маш хурдан хөгжиж, эдийн засаг нь хурдацтай өсөж буйг судалж, сонирхож байсан юм. Тиймээс би Хятадын талаар ажиллаж байсан группийн гишүүн болон уригдсан. Энэ хурлын үеэр би Азийн Хөгжлийн Банкны эдийн засагчтай уулзаж, тэр хүн намайг АХБ-нд ажилд орох өргөдөл гаргаач гэж санал болгож, зөвлөсний дагуу өргөдлөө өгсөн. Энэ ажилд орох гэж нэлээн удсан хэдий ч багагүй хугацааны эцэст орж чадсан. Өдгөө 18 дахь жилдээ ажиллаж байна.

Би 2001 онд анх удаа Монголд ирсэн. Тэр үед би АХБ-ын Монгол Улс хариуцсан эдийн засагч байсан учраас зөвхөн эдийн засгийн хүрээнд ажиллаж байсан. Хожим нь би улс орны төсөл, үйл ажиллагааны төлөвлөлтийг эдийн засгийн ажилтай хамт хэрэгжүүлдэг хөтөлбөрүүдийг хариуцсан. Дараагаар нь би Манил дахь АХБ-ын төв байранд Зүүн Азийн хэлтсийн ахлах эдийн засагчаар ажиллаж БНХАУ, Монгол Улсыг хариуцах болсон юм. Хоёр жилийн өмнө АХБ-ын Монгол Улсыг хариуцсан

суурин төлөөлөгчөөр томилогдсон.

Таны түүхийг сонсож байхад надад ихээхэн сэтгэгдэл төрүүлээ. Тиймээс би Монголын залуу эдийн засагчдад зөвлөгөө өгөөч гэж хүсч байна.

Юун түрүүнд хийж чаддаг зүйлээрээ шаргуу ажиллаарай гэж зөвлөх байна. Мэдээжийн хэрэг зөвлөгөө өгөхөд хэцүү. Тиймээс би өөртөө өгч байсан тэрхүү зөвлөгөөг өгье. Ямар ч тохиолдолд битгий бууж өгөөрэй. Шаргуу хөдөлмөрлөж, нээлттэйгээр сэтгэж байх хэрэгтэй. Хэрвээ боломж олдвол түүнийг бүү өнгөрөө. Зарим чухал шийдвэрийг эрсдэл дагаж байдаг. Түүнээс бүү ай.

АХБ-д элсэх үед эх орон, гэр бүл, ард түмэн, хэл, хоол хүнсээ (инээв) ардаа орхиод Ази тив рүү шилжин ирэх шийдвэрийг гаргасан нь миний хувьд маш чухал байлаа. Томоохон сорилт байсан хэдий ч анх төсөөлж байсан шиг тийм хэцүү байгаагүй. Энэ нь миний дээр дурдсан эрсдэлээс айхгүйгээр боломжийг ашигласан тод жишээ юм. Түүнчлэн, боломжийг ашиглах нь таны оюуны цар хүрээ, харах өнцгийг нээх, илүү ихийг сурч мэдэх, бусад олон туршлага, тухайлбал, дэлхийн бусад улс оронд эдийн засгийн туршлага, шилжилт хөдөлгөөн гэх мэт олон зүйлийг сурч, хураах аз завшааныг олгодог.

Ази тив нь өнөөгийн дэлхийн хамгийн динамик - өөрчлөлт ихтэй бүс тул энэ тивд эдийн засагч байх нь маш том давуу тал. Олон төрлийн улс, эдийн засгийн хөгжлийн түүх, хурд болон үр дүнг шингээсэн энэ том тивд юу болж байгааг мэдэх нь миний хувьд байнгын шинэ зүйл сурах боломж, урам зоригийг авах

эх сурвалж болдог.


Нөгөө талаас танд өгч байсан хамгийн сайн зөвлөгөө юу байсныг хуваалцаач?

АХБ-д элсэх урилгыг хүлээн авахад хэтэрхий их зүйл орхиж байгаа гэж бодсон учраас шийдвэр гаргахад амар байгаагүй тул би эргэлзэж байсан. Мөн би эрсдэл хүлээж байгаа гэж бодсон. Гэвч хүмүүс надад энэ нь насан туршийн шийдвэр биш болохоор намайг ядаж оролдоод үзэх хэрэгтэй гэж зөвлөж байсан юм. Хэрэв аль нэг зүйл надад таалагдахгүй эсвэл өөрчлөлтөд дасах боломжгүй байвал эргэж ирэх боломж үргэлж нээлттэй гэж хүмүүс хэлсэн. Би тэр хүмүүсийн зөвлөгөөг даган АХБ-д хоёроос гурван жил ажиллана гэж төлөвлөж байсан юм. Одоо би 18 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд буцах талаар бодохгүй байгаа!

Та их зүйлийг золиосолжээ, таны бүх хүчин чармайлтад чин сэтгэлээсээ талархаж байгаагаа илэрхийлье. Үүгээр бидний ярилцлага дуусч байна. Танд өөр дурдалгүй өнгөрөөсөн зүйл байна уу?

Монгол бол үнэхээр гайхалтай, үзэсгэлэнтэй орон. Энд анх ирснээс хойш надад гэртээ байгаа мэт дотно санагдсаар ирсэн. Монголын ард түмэн их найрсаг, халуун дулаан бөгөөд би Монголд байхдаа үргэлж баяртай байдаг. Монгол Улс үнэхээр үзэсгэлэнтэй гэдгийг дахин хэлье! Би хөдөө явах үнэхээр дуртай. Хотоос холдон хөдөө явахад гайхалтай гоо үзэсгэлэнтэй өөр ертөнцөд очдог. Миний хувьд энд ажиллаж байгаа нь томоохон хувь заяа мэт санагддаг.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ.ДОЛЛАРААР, 30/1 ӨДРИЙН БАЙДЛААР)



ПОПУЛИЗМЫН ДАВАЛГАА БА БРАЗИЛ УЛСЫН ОДООГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ ЖАИР БОЛСОНАРО

Эх сурвалж: biznews.com

Популизм гэж юу вэ? Яагаад бид популизм эрчээ авч байгаад санаа зовох хэрэгтэй вэ? зэрэг асуулт олон улсын хэвлэлээр гарах боллоо. Бид энэ дугаараараа популизм ба түүний эдийн засаг дахь нөлөөллийн талаар, Латин Америкийн хамгийн том улс болох Бразилын жишээн дээр, шинээр сонгогдсон ерөнхийлөгч Жаир Болсанарогийн бодлого дээр үндэслэн тайлбарлахаар зорилоо. Энэхүү нийтлэлийг Экономист сэтгүүлийн өнгөрсөн жилийн хамгийн их уншигдсан нийтлэлээс эх сурвалж аван уншигч та бүхэнд хүргэж байна.

ПОПУЛИЗМ ГЭЖ ЮУ ВЭ?

Популизм нь “popular” буюу алдартай, түгээмэл гэсэн үгнээс үүдэлтэй бөгөөд удирдагчид буюу элитүүд энгийн ард иргэдийн эрх ашиг, хүсэл сонирхлыг тоохгүй байгаа хэмээн итгэх үед тэднээс дэмжлэг авах улс төрийн нэгэн аргачлал билээ. Энгийнээр тайлбарлавал, иргэдийн зовлонгоор түрүү барьж өөрсдийн улс төрийн ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх зорилготой улс төрчдийг популистүүд буюу “попчид” гэж нэрлэдэг байх нь. Тэд тухайн цаг үед тохиож буй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг ашиглаж, ард иргэдэд тулгамдсан асуудлуудыг далимдуулан эрх мэдэл олж авахыг оролддог. Гэхдээ эцсийн үр дүнг нь харвал тэд ихэнхдээ өөрсдийн, эсвэл бүлгийн ашиг сонирхлыг өндөрт тавьж, зорилгодоо хүрсний дараа энгийн ард иргэдийг

мартаж орхидог. Үүний нэг жишээ Бразил улсын шинэ ерөнхийлөгч Болсанаро болохыг олон улсад онцолж байна.

ЖАИР БОЛСОНАРО БА БРАЗИЛЫН АРДЧИЛАЛ



Популизм амжилт олохын тулд хэд хэдэн хүчин зүйл хангагдах ёстой ба тэдгээрийн нэг нь доройтсон эдийн засаг. Бразил улс 2014-оос 2016 онд маш хүнд үеийг туулсан. Ажилгүйдэл 12 хувьд хүрч, нэг хүнд ногдох ДНБ 10 хувиар буурч, улс төрийн авлигатай холбоотой скандалууд нэг нэгээрээ илэрч, гудамжинд гэмт хэрэг ихэссэн. Энэ үед Бразилын ард иргэд аргаа барж, өөрчлөлтийг эрэлхийлэн, авлигад өртсөн улс төрчид болон гэмт хэрэгтнүүдээс салахыг хүсэх болсон. Болсанаро энэ боломжийг сонгуулийн компани

ажилдаа овжноор ашигласан байдаг.

Бразилд мөнгө угаах гэмт хэрэг газар аваад байгаа ба “авто угаалга” хэмээх томоохон гэмт хэрэг ил болсноор улс төрчдийн нэр хүнд маш ихээр унасан. Болсоноро бусад улс төрчдийг байнга шүүмжилж байсан нь энэ хэрэгтэй давхцаж, түүний нэр хүндийг өсгөсөн юм. Тухайлбал, Бразилын анхны эмэгтэй ерөнхийлөгч Дилма Русеф “авто угаалга”-тай нэр холбогдсоноор үүрэгт ажлаа дэд ерөнхийлөгчдөө өгч дараагийн ерөнхийлөгчийн сонгууль болох үед популист улс төрч сонгогдох суурийг бий болгожээ.

Ноён Болсоноро бол конгресст 7 удаа сонгогдсон туршлагатай улс төрч юм. Тэрбээр үзэл бодлоо маш хүчтэй, дуулиантайгаар илэрхийлдэг нэгэн бөгөөд диктатурын дэглэмийг дэмждэг. Дилма Русефийг ерөнхийлөгч, бүх цэргийн командлагч байх үед 500 гаруй цэрэг хохирч, гэмт хэрэг үйлдэгдсэн, 40 гаруй аллага болсон хэмээх шуугианыг дэгдээж Болсоноро өөрийн хүрээлээрээ дамжуулж огцруулахад санал өгсөн байна.

Цаашлаад, түүнийг төрийн эрхэнд гарвал Бразилын ардчилалд маш том аюул нүүрлэнэ хэмээн олон ажиглагчид анхааруулж байсан. Энэ нь ч үнэн болохыг Болсоноро баталсаар байна. Болсонорогийн Бразилыг 20-р зууны Пиночетээр удирдуулж байсан цэргийн дэглэмтэй Чилитэй харьцуулж, ижил болгохыг эрмэлздэг билээ. Тэрбээр Пиночеттэй адил диктатур дэглэмийг таалдаг бөгөөд одоогийн түүний томилсон албан тушаалтнуудын дунд найман цэргийн генерал асан байх ба түүний ойрын хүрээлэлд Бразилын асуудлыг цэргийн хүчээр шийднэ гэдэгт итгэдэг хүмүүс багтдаг. Цаашлаад түүний эдийн засгийн зөвлөх, эдийн засгийн хөгжлийн сайдаар Чикагогийн их сургуулийг төгссөн Пауло Гуедэс ажилладаг бөгөөд Пиночетын үед ч мөн адил тус сургуулийг төгссөн эдийн засагчид зөвлөхөөр нь ажилладаг байжээ. Хэдийгээр эдгээр удирдагчид нь авторитар төрийг чөлөөт эдийн засагтай хослуулах тал дээр ижил боловч Чилийн ард иргэд нь дарангуйлал дунд амьдардаг байсныг санах хэрэгтэй.

БОЛСОНАРОГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Болсоноро Бразилийн яамдын тоог 29 байсныг 15 болгон хоёр дахин цөөрүүлэхээр амласан ч 22 болгож бууруулаад байна. Цаашид Төв банк, Холбооны Засгийн газрын зөвлөл яамны статусгүй болж, яамдын тоо 20-д хүрч мэдэхээр байгаа. Төрийн данхар бүтцийг жижгэрүүлж байгаа нь олон нийтийн талархлыг ихээр

хүлээж байгаа ч, нөгөө талаас эрх мэдлийг хэт их төвлөрүүлж байгаа аж. Тухайлбал, Гуедэсийн гарт сангийн, эдийн засгийн хөгжлийн, гадаад худалдааны, төлөвлөгөөний сайд нарын эрх мэдлийг нэгтгэж “Супер сайд” болгож байна. Гуедэсийн зөвлөгөөгөөр Болсоноро хэд хэдэн популист эдийн засгийн бодлого явуулахаар болоод байгаа юм.

Бразилын эдийн засагт гарч байгаа өөрчлөлтүүдийг дурдвал тэтгэврийн реформ яахын аргагүй тэргүүн эгнээнд бичигдэнэ. Бразил Улсын тэтгэврийн зардал ихээр өсч алдагдлыг нэмэгдүүлсээр байна. Өдгөө тэтгэврийн зардал ДНБ-ийн 8 хувьтай тэнцэж байгаа ч цаашид насжилтаас улбаатай нэмэгдэх хандлагатай байгаа. Нөгөө талаас татварын орчинг зөөлрүүлж, хөнгөрүүлэх амлалттай байгаа нь мөн л төсвийг өндөр дарамтад оруулах нь тодорхой боллоо. Татварыг хөнгөлөх нь бизнесүүдэд дэмжлэг болж, саарал эдийн засгийг ил болгох давуу талтай ч популист сэдэл нь эргээд улсын эдийн засгийг туйлдуулах аюултай. Ялангуяа хэт зөөлөн төсвийн бодлого нь мөнгөний бодлогын орон зайг хумьж, бодлогын хүүг чангаруулахад хүргэдэг. Иргэд төсөв мөнгөний бодлогын хослол гэдгийг нэг чиглэлд ажиллахтай андуурч боддог ба хоёр бодлогын зөв хослол гэдэг нь мөчлөг сөрсөн, тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг зорьсон, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлсэн, шаардлагатай үед хоорондоо зөрсөн байх явдал юм.

ПОПУЛИЗМ МУУ ХЭРЭГ ҮҮ? ЯАГААД БИД САНАА ЗОВОХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа популизмын давллага эрчтэй тархаж байгаа билээ. Бразилд болон дэлхий дахинаа популизмаас болж олон хүн хохирч байна. Популист улс төрчдийн гадаад худалдааны бодлого нь олон талт бус хоёр талт, протекционист бодлого руу чиглэдэг. Энэ орнуудад дэгдсэн энэ популизм худалдааны маргааныг дэгдээгээд байгаа ба хэрвээ даамжрах юм бол 2020 он гэхэд дэлхийн нийтийн ДНБ 75 хувиар хумигдах эрсдэлтэй талаар ОУВС мэдээлж байсан. Бид мөн өмнөх дугааруудад дэлхийн дараагийн эдийн засгийн хямрал ойртож буй талаар мэдээлсэн билээ. Тэр үед 2008 оных шиг дэлхийн улс орнууд эв нэгдэлтэйгээр асуудлыг шийдэж чадахгүйд хүрч магадгүй. Учир нь популистууд хаалттай нийгмийг уриалж ард иргэд нь ч үүнийг дэмжиж байгаа билээ.

Эх сурвалж: <https://www.economist.com/leaders/2018/09/20/jair-bolsonaro-latin-americas-latest-menace>



ГЛОБАЛ ОРЧИН: ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО БОЛОВСРУУЛЖ, ХЭРЭГЖҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДЛУУД

Монголбанкнаас улирал бүр эрхлэн гаргадаг "МӨНГӨ-САНХҮҮ-БАЯЛАГ" сэтгүүлийн 10 дахь дугаараас онцлов.

Монголбанкны дэд ерөнхийлөгч **Б.ЛХАГВАСҮРЭН**

1. УДИРТГАЛ

Өнгөрсөн хугацаанд дэлхийн эдийн засагт хоёр том хямрал болж байсан бөгөөд эдгээр хямралын дараа макро эдийн засгийн талаарх ойлголт болоод макро эдийн засгийн бодлого өөрчлөгдсөн байдаг. Үүнд:

А. Их хямрал 1930 он

В. Стагфляци 1970 он


1.1. Олж авсан сургамж

А. Санхүүгийн салбар: Санхүүгийн хямрал нь хөгжиж буй орнуудад төдийгүй хөгжингүй орнуудад ихээр тохиолдож байна. Санхүүгийн салбарыг сайн зохицуулаагүйгээс гарах хор уршиг нь маш их бөгөөд дэлхий даяар санхүүгийн хямрал дахин нүүрлэж магадгүй тул санхүүгийн салбар, түүнийг ойлгох асуудал маш чухлаар тавигдаж байна.

В. Хэлбэлзэл (бизнесийн мөчлөг): Макро эдийн засгийн үзүүлэлт нь байнгын хэлбэлзэлд байдаг бөгөөд макро эдийн засаг нь аливаа гадаад, дотоод шокод өртөж байдаг. Эдийн засгийн хэлбэлзлийг "бизнесийн мөчлөг" гэж нэрлэдэг. Макро эдийн засгийн бодлогын хувьд эдийн засгийн мөчлөг тус бүрт тохирсон бодлого хэрэгжүүлэх нь чухал юм.

С. Бага хүүний түвшин: Хөгжингүй улс орнуудын хүүний түвшин багасаж байгаа бөгөөд дэлхийн ихэнх улс орнууд бага хүүний түвшин бүхий макро эдийн засгийн орчинтой байна. Зураг 1-т зарим улс орны жилийн инфляцийн түвшинг дүрслэв. Хүүний түвшин хэт бага байгаагаас шалтгаалан дэлхийн хөгжингүй орнуудын Төв банкууд эдийн засгийн хямралыг уламжлалт мөнгөний бодлогын арга хэрэгслээр удирдах боломж хязгаарлагдмал болж байна. Учир нь хүүний түвшинг тэгээс багад хүргэж болохгүй тул хүүг бууруулж, мөнгөний зөөлөн бодлого баримтлан эдийн засгаа дэмжих боломжгүй болоод байна.

Зураг 1. Зарим улс орны жилийн инфляцийн түвшин



Эх сурвалж: FRB, Haver, CBO Forecast

D. Тэгш бус байдал: Орчин үеийн эдийн засагт бий болоод байгаа нэг томоохон хүндрэл нь орлогын тэгш бус байдал юм. Орлогын тэгш бус байдал нэмэгдэх нь эдийн засагт сөрөг нөлөө учруулдаг бөгөөд хэрхэн тэгш бус байдлыг багасгах вэ? гэдэг нь бодлого боловсруулагчдад томоохон сорилт болж байна.

2. МӨНГӨНИЙ БОДЛОГО

Нэрлэсэн хүүний түвшин нам дор байгаагийн дээр богино хугацаатай хүүний түвшинг тэгээс бага байлгах боломжгүйгээс хөгжингүй орнуудын Төв банк эдийн засгийн хямралыг уламжлалт мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан сэргээх боломж хязгаарлагдмал болж байна.

Иймд энэхүү бага хүүтэй эдийн засгийн орчинд Төв банкны хувьд тулгамдаж буй үндсэн хоёр бэрхшээл байна:

1. Нэрлэсэн хүүний бууралтаас шалтгаалан мөнгөний бодлогын хэрэгсэл болон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх арга хэлбэрт орох өөрчлөлт, үр дагавар;
2. Төв банкны хараат бус байдал буюу Төв банк төрийн мөнгөний бодлогын шийдвэрийг үргэлжлүүлэн бие дааж хэрэгжүүлэх эсэх.

2.1. Хөгжингүй орнуудын Төв банкны баримтлах бодлого

Зарим орны Төв банк дан ганц богино хугацааны хүүг удирдахаас илүүтэйгээр уламжлалт бус шинэ мөнгөний

бодлогын арга хэрэгслийг ашиглан урт хугацааны хүүг удирдаж байна. Дараах үндсэн дөрвөн төрлийн уламжлалт бус мөнгөний бодлогыг Төв банк хэрэгжүүлж байна:

- Хүлээлтээр дамжуулж ирээдүйд чиглэх бодлого;
- Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх уламжлалт бус бодлого (Quantitative easing);
- Сөрөг хүүний бодлого (Negative interest rates);
- Өгөөжийн муруйг удирдах бодлого (Yield curve control).

2.2. Бодлогын дараалал

ХНБ-ны зүгээс мөнгөний бодлогыг ямар дарааллаар авч хэрэгжүүлэх талаар байр сууриа илэрхийлсэн байна. Үүнд:

1. Уламжлалт мөнгөний бодлого;
2. Хүлээлтээр дамжуулж ирээдүйд чиглэх бодлого;
3. Мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх уламжлалт бус бодлого (зөвхөн хямралын үед хэрэгжүүлэх);
4. Сөрөг хүү болон өгөөжийн муруйг удирдах бодлого (ХНБ-ны хувьд ойрын ирээдүйд хэрэгжүүлэх шаардлага байхгүй гэж үзэж байгаа).

2.3. Төв банкны хараат бус байдал

Төв банкны бие даасан, хараат бус байдал нь тухайн орны эдийн засгийн тогтвортой өсөлт, санхүүгийн тогтвортой байдалд голлох үүрэг гүйцэтгэдэг. Орчин үеийн Төв банкны бие даасан, хараат бус байдалд дараахь дөрвөн шинж чанар байдаг:

1. Төв банкны удирдлага, зохион байгуулалт, бүтцийг парламентаас томилогдсон эрх бүхий төлөөлөл тодорхойлж байдаг;
2. Төв банкны мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, явц, хэрэгжилтэд эрх бүхий парламентын төлөөлөл тогтмол хяналт тавьж, Төв банк тайлагнадаг;
3. Төв банк нь мөнгөний бодлогын үндсэн зорилтын хүрээнд мөнгөний бодлогын арга хэрэгслийг бие даан хэрэгжүүлдэг;
4. Дунд хугацаанд парламентын төлөөлөл нь Төв банкны явуулж буй зүй зохисгүй бодлогод бүтцийн өөрчлөлт хийх замаар хариу үйлдэл гаргадаг.

2.4. Уламжлалт бус мөнгөний бодлогын хэрэгжилт (Монголбанкны хувьд)

Нэрлэсэн хүүний болон инфляцийн түвшин нам дор, эдийн засгийн өсөлтийг тэлэх боломж хязгаарлагдмал хөгжингүй орнуудын Төв банк эдийн засгаа идэвхжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй эдгээр дөрвөн төрлийн

уламжлалт бус мөнгөний бодлогыг манай орны хувьд ашиглах хэрэгцээ, шаардлага байхгүй юм.


3. САНГИЙН БОДЛОГО

Макро эдийн засгийн үндсэн зорилт болох урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, инфляцийг тогтворжуулах болон ажилгүйдлийг бууруулах зэрэг эдийн засгийн хөгжлийн тулгуур асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төрийн үйл ажиллагааг “Сангийн бодлого” гэнэ. Сангийн бодлогыг өөрөөр “Төсвийн бодлого” гэж нэрлэдэг ба засгийн газрын зардал (төсөв), шилжих төлбөр болон татвараар дамжуулан хэрэгждэг. Мөн сангийн бодлогыг зорилтот болон зорилтот бус гэж хоёр ангилдаг.

3.1. Төсөв мөнгөний бодлогын уялдаа

Төсөв, мөнгөний бодлогын уялдаа нь тухайн орны санхүүгийн салбарын гүнзгийрэлт, ханшийн дэглэм, институцийн бүтэц зэрэг онцлог шинжээс хамаардаг. Төсвийн бодлого нь урт хугацааны тогтвортой байдалд чиглэх ёстой бөгөөд мөнгөний бодлого нь үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтын хүрээнд макро эдийн засгийн болоод санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгддэг.

Зураг 2. Монгол Улсын эдийн засгийн мөчлөг ба төсвийн бодлого



Эх сурвалж: УСХ

Монгол Улсын төсвийн бодлого нь эдийн засгийн мөчлөгтэй тохирч байгаа эсэхийг шалгахын тулд гарцын зөрүү (output gap)-г тооцооллоо (Л.Даваажаргал, Б.Хүслэн, 2018). Зураг 2-оос харахад, ихэвчлэн (барг жил бүр) төсвийн тэнцэл алдагдалтай буюу сангийн бодлогоор дамжуулан эдийн засгийг тэлдэг байна.

4. САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЛААР ДАХИН ЭРГЭЦҮҮЛЭХ НЬ

Эдийн засгийн их хямрал (the global financial crisis)-аас хойш олон улсын хэмжээнд санхүүгийн тогтвортой байдлын зохицуулалтыг шинэчилж эхэлсэн билээ. 2008

онд “Их 20”-ын уулзалтаас “Санхүүгийн системийн шинэчлэл”-ийн хөтөлбөрийг баталсан бөгөөд уг хөтөлбөр батлагдсанаар олон улсын санхүүгийн хямралын үндсэн шалтгааныг арилгах, санхүүгийн салбарыг илүү нээлттэй, тогтвортой болгож, уг салбарын бодит эдийн засагт гүйцэтгэх үр ашгийг дээшлүүлэн санхүүжилтийн эх үүсвэрийн эрсдэлийг багасгах боломж бүрдсэн юм.

4.1. СТБЗ-ийн хэтийн зорилго

2008 оны санхүүгийн хямралаас хойших хугацаанд СТБЗ-ийн гишүүн орнууд хямралын үндсэн шалтгааныг тодорхойлох, өргөн хүрээний санхүүгийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэхээр нэгдсэн шийдэлд хүрсэн бөгөөд илүү уян хатан, тогтвортой санхүүгийн байгууллага, зах зээлийг бий болгох, хэт томоос уналт бий болох “too big to fail” үйл явцыг дуусгавар болгох, үүсмэл санхүүгийн зах зээлийн эрсдэлийг бууруулах, “сүүдрийн банкны систем”-ийг зах зээлд суурилсан тогтолцоонд шилжүүлэх зэрэг дөрвөн үндсэн чиглэлээр хэтийн зорилгоо тодорхойлжээ.

4.2. Базелийн хороо ба Базел III стандарт

2017 онд Базел III стандартыг гарган Базел I, Базел II стандартын хамт улс орнууд мөрдөж байна. Базел III стандартын хүрээнд дараах зүйлийг голлон тодорхойлсон байна. Үүнд:

- Базел III стандартын эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг албан журмаар шууд мөрдүүлэх шаардлага гишүүн орнуудад тавигдсан ба энэ хүрээнд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх зохистой харьцаа (liquidity coverage ratio), санхүүгийн хөшүүргийн харьцаа (leverage ratio) болон системийн ач холбогдолтой банкны хүрээг тодорхойлох зэрэг зохицуулалтын төслийг эцэслээд байна.
- Базел III стандартаар хөшүүргийн харьцааг тодорхойлох нэгдсэн ойлголтод хүрч, цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (Net stable funding ratio)-ны стандартыг баталжээ.

4.3. Санхүүгийн тогтвортой байдлыг хангах зохицуулалт: Макро зохистой бодлого

АНУ-ын дээрх жишээнээс харахад, эдийн засгийн хямралаас шалтгаалж их хэмжээний санхүүгийн зардал үүсдэг учраас бодлого боловсруулагчид дэлхийн хэмжээнд санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд ихэнх зохицуулалтыг дахин хэлэлцэж, шинэчилсэн ажээ.

Макро зохистой бодлогын тодорхойлолт: Макро зохистой бодлого гэдэг нь санхүүгийн нийт системийн

эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлогын цогц арга хэмжээ юм. Энэхүү бодлогын үндсэн зорилт нь хуримтлагдаж буй системийн эрсдэлийг хязгаарлах замаар санхүүгийн тогтвортой байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, системийн эрсдэл нэгэнт үүсэх нь тодорхой болсон тохиолдолд түүнд бэлтгэлтэй байх болон тэрхүү эрсдэлийг алдагдал багатайгаар туулах явдал мөн.

Макро зохистой бодлогын үндсэн арга хэрэгсэл: Макро зохистой бодлогын гол хэрэгсэл нь системийн эрсдэлийг удирдах зорилго бүхий зохистой харьцааны үзүүлэлт байдаг. Тухайн орны эдийн засгийн нөхцөл байдал болон ирээдүйд тулгарч болзошгүй эрсдэлээс хамааран улс орнууд макро зохистой арга хэрэгслээс сонголт хийж хэрэгжүүлдэг.

4.4. Макро зохистой бодлогын Монгол Улс дахь хэрэгжилт

Монголбанкнаас санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор Монголбанкны макро зохистой бодлогын үйл ажиллагааны чиг үүрэг, арга хэлбэрийг тодорхойлж, макро зохистой бодлогын хэрэгслийг ашиглах, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгохоор ажиллаж байна. Тухайлбал:

- Макро зохистой бодлогын чиг үүргийг тодорхойлох;
- Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн салбарын эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх болон эрсдэл даах чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
- Банкны салбарын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлд.

5. ТЭГШ БУС БАЙДАЛ БА ӨСӨЛТ: БОДЛОГЫН АСУУДЛУУД

Хөгжиж буй болон хөгжингүй орнууд эдийн засгийн өсөлтийн асуудлыг ялгаатай байдлаар авч үздэг. Хөгжингүй орнууд эдийн засгийг их хэмжээгээр өсгөхөөс илүүтэйгээр тогтвортой байлгах бодлогын хувилбарыг сонгодог бол хөгжиж буй орнууд эдийн засгийн өсөлтийг их хэмжээгээр нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх сонирхолтой байдаг.

5.1. Судлагдсан байдал

Олонх улс орны зэрэгцүүлсэн тоон мэдээллийг ашигласан судалгааны ажлууд орлогын тэгш бус

байдал болон эдийн засгийн өсөлт нь хоорондоо сөрөг хамааралтай гэж дүгнэсэн байдаг.

5.2. Тэгш бус байдал, өсөлтийн хамаарал

Ostry ба бусад (2014) нар 153 улс орны 2013 оны нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлтийн таамаглал болон орлогын тэгш бус байдал (Жини)-ын итгэлцүүрийн хамаарлыг судалсан. Энд Жини итгэлцүүр [0] хувьтай тэнцүү үед төгс тэнцвэр оршиж байна гэж ойлгох бол 100 хувьтай тэнцүү үед тэгш бус байдал хамгийн их байна гэсэн үг юм. Тэгш бус байдал эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөтэй гарсан хэдий ч хүчтэй хамааралтай гэдгийг нотолж чадахгүй байна.

5.3. Оновчтой бодлогын хувилбарууд

Хэдийгээр ихэнх судалгааны ажил тэгш бус байдал болон өсөлтийн хооронд сөрөг хамаарал илрүүлсэн хэдий ч тухайн хамаарал тийм ч хүчтэй байгаагүй нь тэгш бус байдлыг бууруулах бүх төрлийн арга хэмжээ нь эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлж чадна гэсэн үг биш юм. Орчин үеийн макро эдийн засагт улс орнуудын бодит үр дүнтэй бодлогын жишээн дээр тулгуурласан дараах арга хэмжээг түлхүү ашиглаж байна.

6. ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДЛУУД

6.1. АНУ-ын ам.долларын олон улсын худалдаан дахь үүрэг

АНУ-ын ам.доллар нь олон улсын худалдааны үнэ, хэмжээг тодорхойлогч хамгийн чухал хүчин зүйл болж байна. Судлаачдын үзэж байгаагаар ам.долларын ханш нь олон улсын эдийн засгийг таамаглагч хамгийн чухал үзүүлэлт болж байгааг онцолжээ. Өнөөдрийн байдлаар АНУ-ын үндэсний валют-ам.долларын бүс (US dollar zone) 1950 оноос хойш маш эрчимтэй тэлж, дэлхийн ихэнх улс орон нөөцийн валютаа ам.доллараар бүрдүүлж байна. Мөн ЗХУ-ын задралаас үүдэн ОХУ, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан хамтын нөхөрлөлийн орнууд нөөцийн валютаа рублиас ам.долларт шилжүүлсний дүнд АНУ-ын ам.доллар нь олон улсын худалдааны хамгийн чухал валютын нэг болоод байна.

6.2. Олон улсын худалдаа ба хамгаалах бодлого (protectionism)

Өнөөдрийн нөхцөл байдлаас харахад, зарим хөгжингүй орнуудын Засгийн газар гаалийн тарифаар дамжуулан дотоодын үйлдвэрлэгчдээ хамгаалах бодлогыг эхлүүлэхэд бэлэн байна. DeLong ба Ripoll (2006) нар үнийн дүнгийн тариф, өсөлтийн хоорондын хамаарлыг нийт 60 улсын 1975-2000 оны панел тоон өгөгдлөөр судалсан байна. Тэдний судалгааны үр дүнгээр бага орлоготой орнуудын хувьд тариф болон эдийн засгийн өсөлтийн хооронд ямар нэг хамаарал оршдоггүй гэдэг нь харагджээ. Харин хөгжингүй орнуудын хувьд тариф нэмэгдэх нь эдийн засгийн өсөлтийг бууруулдаг байна.

ДҮГНЭЛТ

Дэлхийн худалдаа, санхүү болон Төв банкны нөөц бүрдүүлэлтэд ам.доллар давамгайлж байгаа олон улсын валютын системийн өнөөгийн бүтэц нь шинэ шинэ сорилтыг хүн төрөлхтний өмнө тавьж байна. Тухайлбал, АНУ-ын эрсдэлгүй бондын эрэлт болон тус орны энэхүү эрсдэлгүй бондын бий болгох санхүүгийн чадамжийн хооронд Триффин дилемм үүсч байгаа дээр нэмээд АНУ-ын мөнгөний бодлого нь дэлхийн худалдаанд дам нөлөөг үзүүлж байна. Түүнчлэн, олон улсын зах зээл дээр сангууд дахь ам.долларын үүрэг өндөр байгаагаас шалтгаалж АНУ-аас бусад орны хувьд ам.долларын хэлбэлзэлд санхүүгийн тэнцлийг маш өртөмтгий болгож байна (Avdjiev ба бусад (2016)).

Өмнөх хугацаанд тохиосон олон тооны хямрал нь хөгжиж буй 80-90 орчим орныг ирээдүйд учрах хүндрэлтэй үед ашиглах хямралын санг гадаад валютын нөөц хэлбэрээр хуримтлуулахад хүргэсэн юм. Энэхүү гадаад валютын нөөц нь тухайн улсуудыг хямралд орсон эсэхээс үл хамаарч дэжлэг болж байгаа бөгөөд макро зохистой бодлогын нэгэн хэсэг болж өгч байна. Aizenman and Sun (2009) судалгааны үр дүнд хөгжиж буй улс орнуудын олонх нь гадаад валютын нөөцийн 25 хувиас илүүг шавхах хүсэлгүй байдаг нь тогтоогджээ. Гэвч тэдний судалгааны дүнгээс яг хэдий хэмжээний гадаад валютын нөөцийг хямралын үед ашиглах талаар тодорхой нэгдсэн дүгнэлт гараагүй л байна.

БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

Аль ч улсын санхүүгийн зах зээлийн салшгүй нэг хэсэг бол банкны салбар байдаг. Банк нь санхүүгийн зуучлал, хуримтлал, хөрөнгийн хуваарилалт зэргийг хамгийн үр ашигтай, зүй зохистой гүйцэтгэдэг бүтэц учраас тэр биз. Гэхдээ мөнгийг итгэлцэл гэдэг маш чухал зүйл байнга дагаж явдаг учраас итгэлцэлгүйгээр энэ салбар нуран унах болно. Тиймээс ч кредит гэдэг үг нь зээл болон итгэл гэсэн давхар утгыг илэрхийлдэг байна.

Банкны бизнес нь эздийн өмч хэмээх тодорхой хэмжээний хөрөнгө дээр үндэслэж бусдаас хадгаламж татаж, тэрхүү хадгаламжийг ашиглан хэрэгцээтэй, найдвартай этгээдэд зээл зэрэг санхүүжилт олгодог. Үүнийг санхүүгийн хөшүүрэг гэж хэлэх бөгөөд Архимедийн хэлсэн алдарт үг "Надад тулах цэг өг, би дэлхийг эргүүлбэ" гэсэнтэй ижил хууль үйлчилдэг. Өөрөөр хэлбэл банкны эзэд анх банк байгуулахдаа хөрөнгө оруулалт хийх ба тогтмол тэр хэмжээгээ хадгалж байх үүрэгтэй. Уг хэмжээг өөрийн хөрөнгийн зохистой хэмжээ гэж нэрлэх бөгөөд Монгол Улсад 12 орчим хувь байдаг. 12 орчим хувийн өөрийн хөрөнгийг ашиглаж 88 хувийн бусдын хөрөнгийг өөртөө татан, зээл гаргаж үүнээс ашиг олохыг санхүүгийн хөшүүрэг ашиглах гэнэ.



Банкны олгосон зээл төлөгдөхөө больж, алдагдалтай ажиллахад банкны өөрийн хөрөнгө буурч эхэлдэг. Монгол Улсын банкуудад саяхан активын чанарын үнэлгээ хэмээх шалгалт орж, чанаргүй зээл буюу түүнд

харгалзах барьцаа хөрөнгийн бодит хэмжээг үнэлсэн. Үр дүнд нь банкуудын актив буюу зээлийг дахин үнэлж, заримыг нь чанаргүй болгож ангилснаар чанаргүй зээлийн хэмжээ 2018 оны сүүлээр 2.0 их наяд төгрөгөөр өсч, банкууд 200 орчим тэрбум төгрөгийн алдагдлыг хүлээн зөвшөөрсөн.



Эдгээр нь эрүүл процесс бөгөөд 2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш Европын Холбоо, АНУ-д нэвтэрсэн жишиг юм. Гэтэл үүнийг банкууд дампуурах гэж байгаа мэтээр, сөргөөр бичиж байгаа нь өөрөө итгэл дээр тогтдог салбарыг ганхуулах аюултай.

Хэвийн ажиллаж байсан нэгэн банк дампуурсан түүхийн талаар бичье. Нарийн боовны мухлагийн эсрэг талд байрлалтай банк байж гэнэ. Нэг өдөр гэнэт аадар бороо орох үед хүмүүс борооноос хоргодох гэж банкны нүүрний саравчинд бөөгнөрөхөөр нь нарийн боовны мухлагийн эзэн тэр банкныг дампуурах гэж байгаа учраас хүмүүс дараалан зогсож байна хэмээн бодож орж ирсэн хүмүүст цуурхал тараажээ. Үр дүнд нь хэвийн ажиллаж байсан банкнаас хүмүүс гэнэтхэн хадгаламжаа нэг зэрэг татаж банкныг жинхэнээс нь дампууралд түлхсэн байдаг.

Дээр дурдсанчлан аливаа санхүүгийн бизнес итгэлцэл дээр тогтдог бөгөөд хэрэв итгэл алдарвал тэр бизнес үгүй болно. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 14 арилжааны банк нь нийт зах зээлийн 95%-ийг бүрдүүлж, энэ хэрээрээ эдийн засгийн цусны эргэлтийг тогтвортой хангасаар байна. Хэрэв цуурхал газар авч иргэд бөөндөө аль нэг банкнаас хадгаламжаа татаж эхлэх үед банк хүндэрч эргээд санхүүгийн зуучлал зогсож, эдийн засагт хөнөөл учруулах аюултай учир үүнээс болгоомжлох хэрэгтэй. Уулаас 20 сая хүртэлх хадгаламжийг Хадгаламжийн даатгалын корпорацаас даатгаж, хамгаалсан байгаа тул айх аюул өмнөхийг бодвол бага болсон билээ.

НЭГДҮГЭЭР САРД 597 КГ АЛТ ХУДАЛДАН АВЛАА

Монголбанк 2019 оны 1 дүгээр сард 597 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үед 1.1 тонн алт худалдан авч байснаас 531 кг дутуу буюу 47%-иар буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны 1 дүгээр сард Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 13 кг алт, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбар 3 кг алтыг худалдаж авсан үзүүлэлттэй байна.

Монголбанкны алт худалдан авалт өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байгаа нь “Ашигт малтмалын тухай хууль”-д 2014 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алтанд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ 2.5 хувь, нэмэлт төлбөрийн хэмжээ 0 хувьтай тэнцүү болгосон хуулийн хугацаа 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дуусгавар болсонтой холбоотой юм.

2019 оны 1 дүгээр сард 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 109,728.25 төгрөг байлаа.

График 1. 2000-2019 онд Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ





График 2. 2019 оны 1 дүгээр сард Монголбанкны алт худалдан авсан үнэ (төгрөг/грамм)



“Хүн нэг өмөө босоод л санхүүгийн мэдлэгтэй болдоггүй”

Шон мэнди
(Дэлхийн банкны зөвлөх)




ТӨСӨВЧИН Аппликэйшн



Энэхүү аппликэйшн нь өөртөө хуримтлал тооцоологч, хадгалагч, зээл тооцоологч, ипотек, төсөвлөгч зэрэг тооцоолууруудыг багтаасан.

www.sankhuuginbolovsrol.mn





 /Mongolbank.mn


 /Санхүүгийн боловсрол

 @mongolbank_mn

 www.mongolbank.mn

 /Mongolbankmn

 info@mongolbank.mn

 11 310081